

Зөв бичих дүрэм

Гарчиг

1. Үндсэн дүрмүүд (1983 он)	4
1.1. ЦАГААН ТОЛГОЙ	4
1.2. ЦАГААН ТОЛГОЙН ҮСГИЙГ ХУВААХ НЬ	5
1.3. ЭГШИГ ҮСЭГ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ	5
1.3.1. Үндсэн ба туслах эгшиг	5
1.3.2. Өргөлтөт ба балархай эгшиг	5
1.3.3. Урт эгшиг	5
1.3.4. Хос эгшиг	6
1.3.5. Эр, эм, саармаг эгшиг	6
1.4. ЭГШИГ ЗОХИЦОХ ЁС	6
1.5. Ы, ИЙ ХОЁРЫГ ЯЛГАЖ БИЧИХ НЬ	7
1.6. Я-ГИЙН ТӨРЛИЙН ҮСГҮҮД	7
1.7. БАЛАРХАЙ ЭГШГИЙН ДҮРЭМ	8
1.7.1. Эгшигт гийгүүлэгч	8
1.7.2. Заримдаг гийгүүлэгч	8
1.7.3. Балархай эгшиг бичих, үл бичих нь	8
1.7.4. Онцгой гийгүүлэгч	9
1.8. Б, В ҮСГИЙГ ЯЛГАЖ БИЧИХ ДҮРЭМ	9
1.9. Г ҮСГИЙГ ЯЛГАЖ БИЧИХ НЬ	9
1.10. Н ҮСГИЙГ ЯЛГАЖ БИЧИХ НЬ	9
1.11. ЯЛГАХ ЭГШИГ	9
1.12. ДАРААЛСАН ГУРВАН ГИЙГҮҮЛЭГЧ	10
1.13. Ж, Ч, Ш-ИЙН ДАРААХ ЭГШИГ	10
1.14. ГЭЭГДЭХ ЭГШГИЙН ДҮРЭМ	10
1.15. ХАТУУ, ЗӨӨЛНИЙ ТЭМДГИЙН ДҮРЭМ	11
1.15.1. Зөөлний тэмдэг солигдох нь	11
1.15.2. Зөөлний тэмдэг үл солигдох нь	12
1.15.3. Тусгаарлагч ъ, ь	12
1.16. УТГАТ ХЭСГИЙГ ЗӨВ БИЧИХ НЬ	12
1.17. ЗАРИМ ТИЙН ЯЛГАЛЫН НӨХЦӨЛИЙГ БИЧИХ НЬ	14
1.18. ҮЕИЙН ТУХАЙ, ҮГ ШИЛЖҮҮЛЭХ НЬ	14
1.19. ТОМ ҮСГЭЭР БИЧИХ НЬ	15
1.20. ҮГ ХУРААЖ БИЧИХ НЬ	16
1.21. ГАДААД ҮГИЙГ БИЧИХ НЬ	16
1.22. СУЛ ҮГ, ДАГАВАР ҮГИЙГ ЗӨВ БИЧИХ НЬ	17
1.23. ЦЭГ, ЦЭГЛЭЛ	18
1.23.1. Цэг	18
1.23.2. Асуултын тэмдэг	18
1.23.3. Анхаарлын тэмдэг	19
1.23.4. Цуваа цэг	19
1.23.5. Давхар цэг	19
1.23.6. Таслал	19
1.23.7. Цэгтэй таслал	20
1.23.8. Хашилт	21
1.23.9. Хаалт	21

1.23.10. Зураас.....	22
1.23.11. Урт зураас	22
1.23.12. Таслалтай зураас	22
1.23.13. Зүйлийн тэмдэг	22
1.23.14. Дэс дарааллыг тэмдэглэх нь.....	22
2. Нэмэлт өөрчлөлт (2011 он).....	23
Тогтоол	23
2.1. Журамласан монгол үгс	24
2.1.1. А-Г	24
2.1.2. Д-Н	26
2.1.3. О-Т	31
2.1.4. У-Я	34
2.2. Журамласан гадаад үгс.....	38
2.2.1. А-Л	38
2.2.2. М-Я.....	42
2.3. Орчуулан хэрэглэх үгс.....	46

1. Үндсэн дүрмүүд (1983 он)

1.1. ЦАГААН ТОЛГОЙ

§ 1. Монгол үсгээр үг яаж бичихийг үзүүлбэл

Үсэг	Үсгийн нэр	хэрэглэх жишээ
А а	А	Арван настай байна.
Б б	Бэ	Бараан самбар байна.
В в	Вэ	Ваар сав аваад яв.
Г г	Гэ	бага гар, хамаг гэр
Д д	Дэ	Долоон адуу ууланд явна.
Е е	Е	Хүүе, ердөө тэгье.
Ё ё	Ё	Ёстой гоёмсог оёжээ.
Ж ж	Жэ	Жаахан ажил хийжээ.
З з	Зэ	Газрын зураг үз.
И и	И	их, шинэ анги
Й й	хагас й	Сайн нохой айлд хэрэгтэй.
К к	Ка	Карл Маркс, коммунизм
Л л	Эл	Лав олон малтай болно.
М м	Эм	Маргааш явмаар юм.
Н н	Эн	Монголын наадам сайхан.
О о	О	Орхонгол олон модтой.
Ө ө	Ө	Өвгөн Мөнх мөнгө өглөө.
П п	Пэ	Пролетари, монополи, Пагдгар
Р р	Эр	Нар, сар гарав.
С с	Эс	Сурлага бас сайн.
Т т	Тэ	Атан тэмээ хүчтэй.
У у	У	Худаг ухаж ус ундруул.
Ү ү	Ү	Сүүтэй үнээ үнэтэй.
Ф ф	Эф	фабрик, Африк
Х х	Ха	Хонио өсгөх хэрэгтэй.
Ц ц	Цэ	Цайгаа буцалга.
Ч ч	Чэ	Чин зориг чамд чухал.

Ш ш	Ша	маш шулуун шударга заншил
Щ щ	Ща	Щедрин (Оросын зохиолч)
Щ щ	хатуугийн тэмдэг	харъя
ы	урт ы	хувьсгалын, соёлын, нарны
ь	зөөлний тэмдэг	үзье, хүрье, хонь, амь
Э э	Э	эрх чөлөөгөө эдэлсэн
Ю ю	Ю	Аюултай юм могой юу?
Я я	Я	Ямар аянд явах вэ?

1.2. ЦАГААН ТОЛГОЙН ҮСГИЙГ ХУВААХ НЬ

§ 2. Монгол бичиг 35 үсэгтэй. Эдгээр үсгийг эгшиг, гийгүүлэгч, тэмдэг гэж гурав хуваана. Уушгинаас гарсан хий амны хөндийгөөр саадгүй чөлөөтэйгөөр гарч хэлэгдэх авиаг эгшиг авиа гэнэ. Уушгинаас гарсан хий амны хөндийгөөр гарахдаа ямар нэг саад хашилт тохиолдож хэлэгдэх авиаг гийгүүлэгч авиа гэнэ. Цагаан толгойн үсгийн а, а, и, о, у, ө, ү, я, е, ё, ю, й, ыгнэ арван гурав нь эгшиг б, в, г, д, ж, з, к, л, м, н, п, р, с, т, ф, х, ц, ч, ш, щ энэ хорь нь гийгүүлэгч ь, ь хоёр нь дуудлагагүй тул эгшиг ч биш, гийгүүлэгч ч биш зүгээр тэмдэг үсэг болно.

1.3. ЭГШИГ ҮСЭГ, ТҮҮНИЙ АНГИЛАЛ

1.3.1. Үндсэн ба туслах эгшиг

§ 3. Эгшиг үсэг 13 боловч монгол хэлний эгшиг авиа 7 юм. Энэ долоон авиаг тэмдэглэх а, э, и, о, у, ө, ү үсгийг үндсэн эгшиг гэнэ. Нөгөө я, е, ё, ю, й, ы зургааг туслах эгшиг гэнэ.

1.3.2. Өргөлтөт ба балархай эгшиг

§ 4. Монгол үгийн эхний үеийн эгшиг дандаа тодорхой хэлэгдэх тул түүнийг өргөлтөт эгшиг гэдэг. Үгийн нэгдүгээр үеэс хойш орох богино эгшгүүд цөм тодорхойгүй хэлэгдэх тул түүнийг балархай эгшиг гэнэ. Жишээлбэл: Гэрэл, мандах гэдэг хоёр үгийн эхний эгшгүүд өргөлттэй ба сүүлийн эгшгүүд балархай юм.

1.3.3. Урт эгшиг

§ 5. Сунгаж удаанаар хэлэх эгшгийг урт эгшиг гэнэ. Урт эгшгийг дөрвөн аргаар тэмдэглэнэ.

1. Үндсэн эгшгийг давхарлаж аа, ээ, оо, уу, өө, үү гэж тэмдэглэнэ.
2. Я, е, ё, ю эгшгийн дараа үндсэн эгшгийн нэгийг давхарлаж яа, яу, еэ, еу, өө, ёо, ёу, юу, юү гэж тэмдэглэнэ.

3. Зөөлөрсөн гийгүүлэгчийн дараах урт эгшгийг бичихдээ зөөлний тэмдгийг и болгож үндсэн эгшиг нэгийг нэмж иа, ио, иу гэж тэмдэглэнэ. Үндсэн эгшиг гурвыг давхарлаж бичихгүй,

4. И эгшгийг уртаар бичихдээ эр үгийн ы, эм үгийн ий гэж ялгаж тэмдэглэнэ. Эр үгийн ы эгшиг дан үсгээр тэмдэглэсэн богино эгшгийн хэлбэртэй боловч урт и эгшиг юм. Эм үгийн ий хос эгшгийн хэлбэртэй боловч урт эгшиг юм. Жишээлбэл: Ардын, ордны, өвлийн, дэрсний гэх мэт.

1.3.4. Хос эгшиг

§6. Нэг үе болж хавсран орсон хоёр өөр эгшгийг хос эгшиг гэнэ. Жишээлбэл: Аймаг, ойр, үнэтэй, үйлдвэр, туйл, яйрах, гуанз гэх мэт. Монгол хэлний хос эгшгийг ай, эй, ой, уй, уй, яй, ёй, юй, хааяа уа, ау гэж тэмдэглэнэ. Монгол хэлэнд “өй” гэсэн хос эгшиг хэрэглэхгүй.

1.3.5. Эр, эм, саармаг эгшиг

§ 7. Арван гурван эгшгээс хэлний угт бүтэх а, о, у, я, е, ю, (ү), ы долоог эр эгшиг гэнэ. Хэлний дунд бүтэх э, ө, ү, е, ю (ү) тавыг эм эгшиг гэнэ. Хэлний үзүүрт бүтэх и, й хоёрыг саармаг эгшиг гэнэ. Эр эгшиг орж бүтсэн үгийг эр үг гэнэ. Эм эгшиг орж бүтсэн үгийг эм үг гэнэ. Саармаг эгшгээр бүтсэн үгэнд залгавар залгахад эм эгшиг гардаг учир саармаг эгшгээр бүтсэн үгийг эм үгэнд тооцно. Жишээлбэл: ишиг-ишгээр, жил-жилүүд, чийг-чийг-тэй гэх мэт.

1.4. ЭГШИГ ЗОХИЦОХ ЁС

§ 8. Үгийн эхний эгшиг, мөнхүү үгийн дараах эгшгийг ялган тогтоох ёсыг эгшиг зохицох ёс гэнэ. Эгшиг хэлний ба уруулын талаар зохицно. Монгол хэлний нэг үгэнд, эм эгшиг хамтран орохгүй. Эр эгшиг эр эгшигтэйгээ, эм эгшиг эм эгшигтэйгээ зохицож орно. Саармаг эгшиг эр, эм ямар ч эгшигтэй зохицон орно. Энэ бол эгшиг хэлний талаар зохицох ёс юм.

Гажилт

1. Хоёр үгнээс бүтсэн нэг үгэнд эр, эм эгшиг орж болно. Жишээлбэл: горьгүй, болохгүй, Батгэрэл гэх мэт.

2. Хааяа үгийн эцсийн урт эгшиг энэ дүрмийг зөрчинө. Жишээлбэл: байжээ, болжээ, гарчээ гэх мэт.

§ 9. Эгшиг уруулын талаар зохицохдоо

1. Үгийн эхний үед а, у байвал хойшид а дагана. Жишээлбэл: авдартай, уламжлахад, хамгаалахаараа, уулзвар гэх мэт.

2. Үгийн эхний үед э, ү, и байвал хойшид э дагана. Жишээлбэл: эрдэм, үзэгдэхэд, жинхэнэ гэх мэт.

3. Үгийн эхний үед о байвал хойшид о дагана. Жишээлбэл: онгоцоор, оролцоход гэх мэт.

4. Үгийн эхний үед ө байвал хойшид ө дагана. Жишээлбэл: мөнгө, өргөдөл, өндөглөхөд гэх мэт.

5. Энэ зохицолд урт, хос, туслах эгшиг хамаарагдана. Жишээлбэл: Ёндон, ольё, уралдаантайгаар, үзье, үдэшлэгтэй, инээдэм, уяатай гэх мэт.

Энэ дүрмийг хүснэгтээр үзүүлбэл:

Үгийн эхний үед ийм эгшиг байвал	Хойшид тохиолдох эгшиг нь
А, у	а
Э, ү, и	Э
о	О
ө	ө

Гажилт

1. уу, үү, юу, юү, яу, ёу, еү, иу эгшгүүд эгшиг зохицох ёсыг зөрчиж орох бөгөөд хойшид дагах эгшгийг өөрийн зохицолд авна. Жишээлбэл: орчуулагч, өрнүүлсэн, оёулахдаа, үеүдэд, хориулан гэх мэт.
2. и, ий, ы, эй эгшгүүд эгшиг зохицох ёсыг зөрчиж орох боловч хойшид дагах эгшиг нь өмнөх эгшгийн зохицолд хамаарагдана. Жишээлбэл: ажиллах, хөгжилдөнө, онийсон, нөхөдтэйгөө, өвстэйхөн, доёйсон гэх мэт.

1.5. Ы, ИЙ ХОЁРЫГ ЯЛГАЖ БИЧИХ НЬ

§10. ы, ий хоёрыг ялгаж бичих дүрэм

1. Урт ы үсгийг эр үгэнд бичнэ. Эм үгэнд ердөө бичихгүй. Жишээлбэл: ардын, нарны, хотыг, уулыг гэх мэт.
2. Эм үгэнд ий үсгийг бичнэ. Жишээлбэл: хүний, эрдмийг, өвлийн, шүлгийг гэх мэт.
3. ий үсгийг эр үгэнд хааяа бичнэ. Үүнд: ж, ч, ш, ь, и, хэлний г үсгээр төгссөн эр үгэнд бичнэ. Жишээлбэл: туужийг, ачийн, багшийн, айргийг, харь-харийн, анги-ангийн гэх мэт.

1.6. Я-ГИЙН ТӨРЛИЙН ҮСГҮҮД

§ 11. я, е, ё, ю дөрөв бол уг нь гийгүүлэгч эгшиг хоёр авиагаар бүтсэн бүхэл үеийг тэмдэглэх үсэг юм. Үүнийг хавсарсан үсгээр жишээ болгон үзүүлье. (Гийгүүлэгч үсгийг 1 үсгээр тэмдэглэв). Я-ia, Е-ie, ie, Ё-io, Ю-iy, iy энэ дөрвөн үсгийг я-гийн төрлийн үсгүүд гэнэ.

§ 12. Эр үгийн эхний үед богино и үсгийг бичихгүй, дандаа я-гийн төрлийн үсгийг бичнэ. Жишээлбэл: мянга, пял, янзага, ёс, хялгана гэх мэт.

§ 13. Юу, яу, ёу, еү эгшгийг ялгаж бичих нь Үгэнд юу мэтээр хэлэгдэх урт эгшгийг юу, яу, ёу, еү дөрвөн янзаар бичнэ. Үгийн үндэс нь я, е, ё үсгээр төгссөн бол түүнийг солихгүй зөвхөн у, ү эгшиг нэмнэ. Жишээлбэл: хоёр-хоёул, хая-хаяул, оё-оёул, үе-үеүд, бие-биеүд гэх мэт. Үгийн үндэс нь я, е, ё үсгээр төгссөн биш бөгөөд ю хэлэгдвэл тэр ю үсгийг бичнэ. Жишээлбэл: аюул, Аюуш, оюун, гиюүрэх гэх мэт.

§ 14. Я-гийн төрлийн эгшиг өмнөх эгшигтэйгээ нийлж урт эгшиг буюу хос эгшиг болдоггүй, тусгай үе хэвээр байна. Жишээлбэл: байя, хөөе, ная, оё, бие гэх мэт. Я-гийн төрлийн эгшиг арын эгшигтэй нийлж урт ба хос эгшгийг бүтээнэ. Жишээлбэл: яарах, үеэс, аюул, оёод, оюутан, оёулах, хаяулах, саяын, гоёыг биеийг гэх мэт.

1.7. БАЛАРХАЙ ЭГШГИЙН ДҮРЭМ

§ 15. Монгол хэлэнд үгийн нэгдүгээр үеэс хойш орсон богино эгшгүүд цөм тодгүй балархай хэлэгдэнэ. Балархай эгшгийг олж бичихэд амаргүй боловч гийгүүлэгч үсгүүдийг хянаж үзвэл зарим гийгүүлэгч үсгүүд заавал эгшиг дагуулж үе бүтээдэг байхад зарим гийгүүлэгч үсгүүд заавал эгшиг дагуулж явдаг биш байна. Энэ байдлаас үндэслэн балархай эгшгийн дүрмийг тогтоохын тулд гийгүүлэгч үсгийг эгшигт гийгүүлэгч, заримдаг гийгүүлэгч, онцгой гийгүүлэгч гэж гурав хуваав.

1.7.1. Эгшигт гийгүүлэгч

§ 16. м, н, г, л, б, в, р энэ долоон гийгүүлэгч үсэг үгэнд орохдоо өмнөө буюу хойноо аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. Үүнийг эгшигт гийгүүлэгч гэнэ. Жишээлбэл: гавар, тохом, цацрал, модон, хөдөлмөр, гарав, үзэл, тасархай гэх мэт. Үүнийг цээжлэхдээ “Монгол баавар” гэнэ.

Гажилт

1. Хэлний угийн н-ийн дараа заахын тийн ялгалын г нөхцөл эгшиггүй бичигдэж болно. Жишээлбэл: байшинг, дүнг, Галсанг, хөвөнг гэх мэт.
2. Тусгай бичигддэг л, нь хоёр эгшиггүй бичигдэнэ. Жишээлбэл: сайн л байна. Хоёр нь үлджээ гэх мэт.

1.7.2. Заримдаг гийгүүлэгч

§ 17. д, т, ж, з, с, ш, ц, ч, х есөн гийгүүлэгч үсэг үгэнд эгшигтэй, эгшиггүй хоёр янзаар бичигдэх тул заримдаг гийгүүлэгч гэнэ. Заримдаг гийгүүлэгч бол эгшигт гийгүүлэгчийн дараа өмнө хойноо эгшиггүй орж болно. Жишээлбэл: Ховд, хагд, амт, тэнд, ард, тэвш, багш, булш, зунш, дарш, эзэмш гэх мэт.

Гажилт

Үйлт нэрийн ирээдүй цагийнх нөхцөлийн өмнө заавал эгшиг бичдэг учир энэ дүрэмд хамаарахгүй. Жишээлбэл: өгөх, явах, олох, хамах, харах гэх мэт.

§ 18. Заримдаг гийгүүлэгч нь заримдаг гийгүүлэгчийн дараа орохдоо сүүлчийн заримдаг нь өмнөө буюу хойноо аль хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ. Жишээлбэл: модот, модтод, хажид, хождох, бусад, бусад, эзэд, батад, ахад, лацад, мөчид, хойшид, буцаж, эцэс, ачит, анжис гэх мэт.

Гажилт

Заримдаг гийгүүлэгчийн дотроос с, х үсгийн дараа т, ч үсэг өмнө хойноо эгшиггүй орж болно. Жишээлбэл: туст нөхөр, түүхт он, усч хүн, түүхч эрдэмтэн гэх мэт.

1.7.3. Балархай эгшиг бичих, үл бичих нь

§ 19. Эгшигт гийгүүлэгчийн дараа үгийн эцэст ямар ч балархай эгшиг бичиж болно. Жишээлбэл: ямба, толбо, алба, Пагма, хурга, хөрөнгө, мөнгө, анги, тогло, ажигла, муна, ирнэ, урва, харва, цэлмэ гэх мэт. Заримдаг гийгүүлэгчийн дараа үгийн эцэст и-ээс өөр балархай эгшиг бичихгүй. Жишээлбэл: салхи, банди, гархи гэх мэт. Энэ дүрмийн § 16, 18 дугаар зүйлд дурдсан балархай эгшгийн дүрмийг мартажгүй тогтооход зориулж томъёогоор үзүүлбэл:

7+э

7 + 9 - э

9 + 9 + э

Эгшигт гийгүүлэгчийг 7-гийн тоогоор, заримдаг гийгүүлэгчийг 9-ийн тоогоор, эгшиг үсгийг э-ээр тэмдэглэв.

1.7.4. Онцгой гийгүүлэгч

§ 20. К, Ф, Ц гурван үсэг монгол үгэнд бичигдэхгүй, зөвхөн гадаадын үгэнд бичигдэнэ. Жишээлбэл: коммунизм, капитал, фабрик, Щорс гэх мэт. П үсэг монгол үгийн дунд ба адагт орохгүй, харин монгол үгийн эхэнд хааяа бичигдэнэ. Жишээлбэл: пагдгар, пүл пал, пээ юу вэ гэх мэт. к, ф, ц, п дөрвөн үсгийг онцгой гийгүүлэгч гэж нэрлэнэ.

1.8. Б, В ҮСГИЙГ ЯЛГАЖ БИЧИХ ДҮРЭМ

§ 21. 1. Б үсгийг ихэвчлэн үгийн эхэнд бичнэ. Үгийн дунд л, м, н, в үсгийн дараа бичнэ. Жишээлбэл: бодлого, толбо, самбар, хэн бэ? явбал гэх мэт.
2. В үсгийг ихэвчлэн үгийн дунд адагт бичнэ. Үгийн эхэнд хааяа цөөн үгэнд бичнэ. Жишээлбэл:ваадан, вандан, ваар, хавав, харав, хөвөвч гэх мэт.

1.9. Г ҮСГИЙГ ЯЛГАЖ БИЧИХ НЬ

§ 22. Г үсгээр хоёр авиаг тэмдэглэнэ

1. Хүүхэн хэл идэвхтэй оролцож “га, го, гу, гы” гэж хэлэгдэх г үсгийг хоолойн г гэнэ. Хоолойн г-ийн ард а, о, у, ы дөрвөн эгшгийн нэгийг бичнэ. Жишээлбэл:арга, аргын, бага, ботго, гудамж гэх мэт.
2. Хэлний угаар хэлэгдэх г үсгийг хэлний г гэнэ. Хэлний ардаа эгшиггүй буюу а, о, у, ы дөрвөөс өөр эгшигтэй байна. Жишээлбэл: аймаг, нутаг, хөрөнгө, цэнгэл, цэцэг, гүйцэтгэх гэх мэт. Хэлний г үсгийн ард залгавар залгахад а, о, у эгшиг орох боловч хэлний г хэвээр байна. Жишээлбэл: хамаг-хамгаас, тоорцог-тоорцгоор, туг-тугууд, аймаг-аймгарх, омог-омгорхуу гэх мэт.

1.10. Н ҮСГИЙГ ЯЛГАЖ БИЧИХ НЬ

§23. Н үсгээр хоёр авиаг тэмдэглэнэ

1.Хэлний үзүүр хатуу тагнайд хүрч хэлэгдэх н авиаг хэлний үзүүрийн н гэнэ. Хэлний үзүүрийн н хойноо эгшиг буюу ь-тэй байна. Жишээлбэл: чанар, үнэг, чоно, явна, нум, нөмөр, оньс, тань гэх мэт.
2.Хэлний үзүүр хатуу тагнайд хүрэхгүй хэлэгдэх н үсгийг хэлний угийн н гэнэ. Хэлний угийн н ардаа эгшиггүй байна. Жишээлбэл: ганган, онгоц, сан, байшин, Лувсан, Сүрэн гэх мэт. Зарим үгийн эцсийн хэлний үзүүрийн н авиа халх аялгуунд хэлний угийн н болж хэлэгддэг бөгөөд залгавар залгахад хэлний үзүүрийн н болох нь тодорхой болно. Жишээлбэл:мэргэн-мэргэнээр, он-оны, үнэн-үнэний гэх мэт.

1.11. ЯЛГАХ ЭГШИГ

§24. Хэлний үзүүрийн н-ийг хэлний угийн н-ээс, хоолойн г үсгийг хэлний г-ээс ялгахын

тул хэлний үзүүрийн н, хоолойн г үсгийн ард бичсэн балархай эгшгийг ялгах эгшиг гэнэ. Жишээлбэл: хана, бага, оно, торго, үнэ, онгоц, өнөр, торни гэх мэт.

Тайлбарлах нь

Өргөлттэй эр, үндсэн эгшиг, мөн урт хос үндсэн эр эгшиг ба ы эгшгийн өмнө орсон г бол их төлөв хоолойн г байна. Жишээлбэл: газар, гуйх, гоожих, тогоо, агуу, даргын, агаар гэх мэт. Балархай эгшгээс бусад эдгээр дурдсан эгшгийг ялгах эгшиг гэж нэрлэхгүй.

1.12. ДАРААЛСАН ГУРВАН ГИЙГҮҮЛЭГЧ

§25. Дараалсан гурван гийгүүлэгчийн гуравдугаар нь хоолойн г, хэлний үзүүрийн н хоёрын нэг бөгөөд түүний арын ялгах балархай эгшгээр үг төгсгөвөл тэр ялгах эгшиг сонстохгүй тул н ба г-ийн өмнө богино эгшиг бичнэ. Үүнийг дараалсан Гурван гийгүүлэгчийн дүрэм гэнэ. Жишээлбэл:

1. Аньсага, бортого, ганзага, жинхэнэ, зулзага, оньсого, турсага, хавтага, харцага, хоромсого, хундага, чагтага, чандага, чогчиго, эрдэнэ, янзага гэх мэт цөөн нэр үг байна.
2. Цаг заах үйл үгийн одоо, ирээдүй цагийн -на, -нэ, -но, -нө нөхцөлийг давхар гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахдаа дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр бичнэ. Жишээлбэл: манд-на-мандана мөлх-нө-мөлхөнө, урс-на-урсана, орш-но-оршино гэх мэт. Дээрх хоёр тохиолдлоос бусад үгэнд балархай эгшгийн дүрмийг зөрчихгүй бол 3 ба 4 гийгүүлэгч дараалан орж болно. Жишээлбэл: урсга, ястны, төрөлхтний, эрхтний гэх мэт.

§26. Дараалсан хоёр гийгүүлэгчийн хоёрдугаар гийгүүлэгч нь хоолойн г, хэлний үзүүрийн н хоёрын нэг байвал түүний өмнө и-гээс бусад балархай эгшиг бичихгүй. Жишээлбэл: авга, алга, тамга, ганга, торго, годгор, хавгар, босго, тошгор, авна, аялна, бодно, маажна, босно, хөшнө гэх мэт. Хэлний үзүүрийн н буюу хоолойн г-ийн өмнө хэлний үзүүрийн н буюу хоолойн г тохиолдвол завсар нь эгшиг бичнэ. Жишээлбэл: унана, дагана, унага, шанага, багана гэх мэт.

1.13. Ж, Ч, Ш-ИЙН ДАРААХ ЭГШИГ

§ 27. Ж, ч, ш-ийн дараах эгшиг

1. Эр үгийн эхний ж, ч, ш гурвын дараа богино и эгшиг бичихгүй, а, о, у гурвын нэгийг бичнэ. Жишээлбэл: шар, чагтага, жаргалан, шороо, чоно, чухал, шугам гэх мэт.
2. Эм үгийн эхний ж, ч, ш-ийн дараа богино э эгшгийг бичихгүй и, ө, ү гурвын нэгийг бичнэ. Жишээлбэл: жил, чимээ, ширээ, чөлөө, шөнө, жүжиг, шүдлэн гэх мэт.
3. Эр эм ямар ч үгийн дунд орсон ж, ч, ш гурвын дараа балархай эгшиг бичих шаардлага гарвал дандаа и эгшиг бичнэ. Жишээлбэл: ажил, ашиг, ишиг, хөгжил, учир, дэвших гэх мэт.
4. ж, ч, ш-ийн дараа ямар ч урт эгшгийг бичиж болно. Жишээлбэл: шаантаг, шээзгий, шүүх, хашаал, чанаржуулах, хөгжөөнө гэх мэт.

1.14. ГЭЭГДЭХ ЭГШГИЙН ДҮРЭМ

§ 28. Үгэнд залгавар залгахад балархай эгшгийн дүрмийн ёсоор шаардагдахгүй болж хасагдах эгшгийг гээгдэх эгшиг гэнэ. Ийнхүү эгшиг гээгдэх гурван тохиолдол байна. Үүнд:

1. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад уг үгийн төгсгөлийн

гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэнэ. Жишээлбэл: олон-олноос, авар-авраад, суртал-суртлаар гэх мэт.

2. И-ээс бусад богино эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад төгсгөлийн балархай эгшиг гээгдэнэ. Жишээлбэл: чарга-чаргыг, хана-ханаар, сана-сануул, эмнэ-эмнүүл, өмнө-өмнөөс гэх мэт.

3. Гийгүүлэгчээр төгссөн үгэнд гийгүүлэгчээр эхэлсэн залгавар залгахдаа өмнө нь эгшиг жийрэглэвэл мөн үгийн эцсийн гийгүүлэгчийн өмнөх эгшиг гээгдэнэ. Жишээлбэл: боловсор-боловсрол, сурагчид-д-сурагчдад, үсэр-х-үсрэх гэх мэт.

Гажилт

1. Оноосон нэрийн төгсгөлийн гийгүүлэгчийн өмнөх балархай эгшгийг гээхгүй.

Жишээлбэл: Матад-Матадаас, Орхон-Орхоны, Пунцаг-Пунцагийг гэх мэт.

2. Галав, төлөв гэх мэт зарим үгийн балархай эгшгийг гээхэд үгийн үндэс ихээхэн өөрчлөгдөхөөр болбол балархай эгшгийг гээхгүй.

3. Уламжлалын зарчим баримталж бичсэн үгийн “и” эгшгийг гээхгүй. Жишээлбэл: тэнхимийн, эрихээр гэх мэт.

§ 29. Нэр үгэнд хэд хэдэн залгавар залгахдаа нэгэнтээ гэж бичсэн эгшгийг сэргээж бичихгүй. Жишээлбэл: бутар-бут-рал, бутралаар, нөхөд-нөхдөд-нөхдөдөө, бэх-бэхэж-бэхэжтүгэй-бэхжих-бэхжихэд гэх мэт.

§ 30. Эгшгийг гээхдээ эгшигт гийгүүлэгч, заримдаг гийгүүлэгчийг эгшиггүйдүүлэх, мөн үгийн дунд орсон ялгах эгшиг, үйлт нэрийн “х”-гийн өмнөх эгшиг, дараалсан гурван гийгүүлэгчийн дүрмээр бичсэн эгшиг, зөөлрүүлэх үүрэгтэй “и” эгшгийг гээх зэргээр балархай эгшгийн дүрмийг зөрчиж болохгүй.

1.15. ХАТУУ, ЗӨӨЛНИЙ ТЭМДГИЙН ДҮРЭМ

§ 31. Эр үгэнд орсон зарим гийгүүлэгчийг уг хэлэгдвэл зохих байраас нь урагшлуулах, тагнайшуулах зэргээр хэлэхийг зөөлрүүлэх гэнэ. Жишээлбэл: бар-барь, хол-холь, ам-амь, зах-захь, тав-тавь гэх мэт. Эм үгийн гийгүүлэгч үсгүүд угаас тагнайшиж зөөлөн хэлэгддэг тул түүнд зөөлний тэмдгийг зөөлрүүлэх үүрэгтэй хэрэглэхгүй. Зөөлөрсөн дан гийгүүлэгчийн ард зөөлний тэмдгийг бичнэ. Хэрэв давхар гийгүүлэгч зөөлөрвөл түүний ард “и” бичнэ. Жишээлбэл: морь, тахь, хонь, архи, орхи, тамхи, болхи, солби, дорви, анги гэх мэт.

1.15.1. Зөөлний тэмдэг солигдох нь

§ 32. 1. Зөөлний тэмдгийн дараа үндсэн эгшиг (а, о, у, и) орвол зөөлний тэмдгийг сольж и болгоно. Жишээлбэл: боль-болиод, дохь-дохио, захь-захиа, сургууль-сургуулийн, харь-хариу гэх мэт.

2. Зөөлний тэмдгийн дараа эгшигт гийгүүлэгч (в, г, л, м, н, р) орвол зөөлний тэмдгийг сольж и болгоно. Жишээлбэл: морь-моринд, соль-соливол, ярь-яриг, барь-баримт, сахь-сахилга, тахь-тахина гэх мэт.

3. Зөөлний тэмдгийн дараа үйлт нэрийн ирээдүй цагийн -х нөхцөл орвол зөөлний тэмдгийг сольж и болгоно. Жишээлбэл: тавь-тавих, ярь-ярих, ань-аних, холь-холих, хумь-хумих гэх мэт.

4. Заримдаг гийгүүлэгчийг зөөлрүүлсэн зөөлний тэмдгийн дараа дахин заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдгийг сольж и болгоно. Жишээлбэл: зохь-зохис, захь-захидал, сахь-сахиж, боть-ботид гэх мэт.

1.15.2. Зөөлний тэмдэг үл солигдох нь

§ 33. Зөөлний тэмдгийн үл солигдох нь

1. Зөөлний тэмдгийн дараа туслах эгшиг (я, ё) орвол зөөлний тэмдэг хэвээр байна. Жишээлбэл: барья, сахья, сольё, дохьё гэх мэт.
2. Эгшигт гийгүүлэгчийг зөөлрүүлсэн зөөлний тэмдгийн дараа заримдаг гийгүүлэгч орвол зөөлний тэмдэг хэвээр байна. Жишээлбэл: барь-барьдаг, барьц, барьзна, амьтан, шуугьж, хальсан гэх мэт.
3. Хоёр үгнээс бүтсэн үгэнд зөөлний тэмдэг хэвээр байна. Жишээлбэл: Дарьбазар, морьгүй гэх мэт.

1.15.3. Тусгаарлагч ъ, ь

- §34.** 1. Эр үгэнд я, ё эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол өмнө нь хатуугийн тэмдгээр тусгаарлаж бичнэ. Жишээлбэл: авья, ольё, угтъя гэх мэт.
2. Эм үгэнд е эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол өмнө нь зөөлний тэмдгээр тусгаарлаж бичнэ. Жишээлбэл: өгье, үзье, тэнцье гэх мэт. Я, е, ё, ю үсгүүд эгшиг ба зөөлний тэмдгийн дараа залгаж ороход өмнө нь хатуу, зөөлний тэмдэг (ъ, ь) бичихгүй. Жишээлбэл: саная, хичээе, олгоё, байя, хөгжөөе, барья, орхиё, цохьё гэх мэт.

1.16. УТГАТ ХЭСГИЙГ ЗӨВ БИЧИХ НЬ

§ 35. Үгийн утгат хэсэг язгуур, дагавар, нөхцөлийг нэг тогтсон хэлбэртэй бичихийг чармайна. Жишээлбэл: Үйл үгийн байдал заадаг -цгаа, -цгээ, -цгоо, -цгөө, -зна, -знэ, -зно, -знө нөхцөлийн бүтцийг ц, з гийгүүлэгчийн ард эгшигтэй бичвэл эгшиг буюу эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгахад балархай эгшиг нь илүүдэх учир нөхцөлийн бүтэц-цагаа, -цгаа; -зана, -зна гэж хоёр янз болж тайлбар дүрэм хэрэгтэй болно. Иймээс байцгаа, байзна, хүлээцгээ, хүлээзнэ, харцгаа, харзна, уншицгаа, уншизна гэж нэг ижил бүтэцтэй бичнэ.

§ 36. Үгэнд залгавар залгахад үгийн үндэс эвдсэн ч болох, эвдээгүй ч болох учир тохиолдвол үгийн үндсийг эвдэхгүйг чухал болгоно. Жишээлбэл: эцэст, тасал-тасалж, товчил-товчилж гэж бичнэ. эцсэд, таслаж, товчлож гэж бичихгүй.

§ 37. Үсгийн дүрэм ёсоор ижил бичиж болмоор боловч үгзүйн зарчмаар өөр өөр бичих үгийг үгийн бүтэц, үгзүйн зарчмыг баримталж бичнэ. Жишээлбэл:
 -хүрэг-зөвшин захирах хэлбэр, сураг гэсэнтэй адилхан утгатай залгавар
 -хүргэ-бусдаар үйлдүүлэх хэв, сурга гэсэнтэй адилхан утгатай залгавар
 -учралаа, хамтралаа, огтлолоо, жуулчлалаа, мэдрэлээ гэхэд юугаа гэсэн асуултад хариулагдах ерөнхийлөн хамаатуулах -аа, -ээ, -оо, -өө нөхцөлтэй жинхэнэ нэр үг байна.
 -учирлаа, хамтарлаа, огтоллоо, жуулчиллаа, мэдэрлээ гэхэд яав гэсэн асуултад хариулагдах цаг заах төлөвийн -лаа, -лээ, -лоо, -лөө нөхцөлтэй үйл үг байна.
 -өргөдөх гэдэг үг бол өргөд-өргөн гэж үгзүйгээр задарна.
 -өргөдөх-өрөгд-өр гэж задарна (үсэг өрөгдөх гэх мэт)

-эндэх (осолдох, цалгардах), эндэхийг шахлаа.

-эндэх (энд байгаа) эндхийн хүн шүү дээ.

-явчих-явчхаад (бүрмөсөн үйлдэх байдал),

яв-явч-явчих-явчихыг, явчихад (үйлт нэрийн ирээдүй цагийн нөхцөлтэй үг).

§ 38. Үйл үгийн үндэс үүсгэх -л дагаврын шаардагдах балархай эгшгийг хаана нь бичих вэ гэвэл:

1. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд -л дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийн ард нь бичнэ. Жишээлбэл: таг-ла, тавла, бөглө, нэрлэ, ажилла, төлөвлө, амла, тугалла, сумла гэх мэт.

2. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд -л дагаврыг залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ. Жишээлбэл: дансал, хагасал, борцол, бутал гэх мэт.

Гажилт

Хэрэв -л дагаврыг залгахад заримдаг гийгүүлэгчийн өмнөх балархай эгшиг гээгдэхээр байвал -л дагаврын шаардагдах эгшгийг ард нь бичнэ. Жишээлбэл: үндэс-үндэслэ, хавтас-хавтасла, идэш-идэшлэ, холтос-холтосло гэх мэт.

3. Зөөлний тэмдгээр төгссөн үгэнд -л дагавар залгахдаа зөөлний тэмдгийг и болгоод -л дагаврыг шууд залгана. Жишээлбэл: цохь-цохил, барь-барил, хань-ханил гэх мэт.

4. Эгшгээр төгссөн үгэнд -л дагаврыг эгшиггүй залгаж бичнэ. Жишээлбэл: тоо-тоол, цай-цайл, хөө-хөөл гэх мэт. Нэр үгийн -л дагавар энэ 38-р зүйлд хамаарагдахгүй.

Жишээлбэл: авар-аврал, -авралаар, явдал, хурал, цугларал гэх мэт.

§ 39. Үйл үгийн бусдаар үйлдүүлэх хэвийн -г нөхцөлийг-га, го, гэ, гө гэж ард нь эгшигтэй бичнэ. Жишээлбэл: сур-сурга, ол-олго, хүр-хүргэ, хөөр-хөөргө гэх мэт. Харин захирах хүсэх төлөвийн -г нөхцөлийг ард нь эгшиггүй бичнэ. Жишээлбэл: сур-сураг, ол-олог, хүр-хүрэг, хөөр-хөөрөг гэх мэт.

§ 40. Нөхцөл үйлийн зэрэгцэх хэлбэрийн -ж, -ч нөхцөлийг үгэнд залгахдаа

1. Эгшгээр төгссөн үгийн хойно -ж нөхцөлийг бичнэ. Жишээлбэл: хурааж, гүйцээж, манаж харайж, орхиж гэх мэт.

2. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд зөвхөн -ж бичнэ. Жишээлбэл: бодож, хатаж, буцаж, оршиж, дасаж, бялхаж, гацаж, засаж, дуусаж, нисэж гэх мэт.

3. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд ихэвчлэн -ж бичих боловч хааяа ч бичих удаа бий.

а) л, м-ийн дараа -ж бичнэ. Жишээлбэл: олж, хамж, нийлж, нэмж гэх мэт.

б) в, г-гийн дараа бараг төлөв -ж бичнэ. Зөвхөн авч, өгч хоёрт -ч бичнэ. Жишээлбэл: хавж, хөвж, сэвж, эгж, бүгж гэх мэт.

в) Урт буюу хос эгшигтэй ганц үетэй бас хоёроос дээш үетэй р-ээр төгссөн үйл үгэнд цөм -ч бичнэ. Жишээлбэл: таарч, тойрч, хөөрч, хуурч, ээрч, хайрч, хагарч, бу-тарч, дулаарч, хөөрч, самарч гэх мэт.

г) Богино эгшигтэй ганц үетэй р-ээр төгссөн үйл үгэнд их төлөв -ж бичнэ. Жишээлбэл: харж, орж, эрж, тарьж, хөрж, үрж гэх мэт.

Гажилт: хүрч, гарч, сурч гэх зэрэг цөөн үг байна. Энэ нь цаг заах үйл үгийн өнгөрөн үргэлжилсэн цагийн -жээ, -чээ нөхцөлийг бичихэд нэгэн адил хамаарагдана. Жишээлбэл: хөржээ, хөөрчээ, дусжээ, дуусжээ, оножээ, авчээ гэх мэт.

§ 41. С үсгээр төгссөн нэр үгэнд үйл үгийн үндэс үүсгэх -д дагаврыг залгахгүй, -т дагаврыг залгана. Жишээлбэл: мөс-мөст-мөстөх, мөхөс-мөхөст, сэвс-сэвст-сэвстэх, тос-тост-тостох, утас-утаст-утастах, хилс-хилст-хилс-тэх, хомс-хомст-хомстох, хөөс-хөөст, цус-цуст-цустах гэх мэт. Бас үйл үгийн бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн -д, -т дагаврыг залгахдаа мөн энэ дүрмийг баримтална. Жишээлбэл: сонс-сонст-сонстох гэх мэт. Гажилт:

С үсгээр төгссөн нэг үг хоёр өөр утга илтгэдэг бол мөн үгэнд -д, -т дагаврын алиныг ч залгаж болно. Жишээлбэл: үсдэх (үснээс шүүрч чангаах), үстэх (үс тогтох буюу үс мэт зүйл бүрхэх), тоосдох (тоос болгох), тоостох (тоостой болох) гэх мэт.

§ 42. Гийгүүлэгчээр төгссөн үгийн хойно -лага, -лого дагаврыг бичнэ. Жишээлбэл: бод-бодлого, зар-зарлага гэх мэт. Эгшиг ба зөөлний тэмдгээр төгссөн үгийн хойно -лга, -лго дагавар бичнэ. Жишээлбэл: буу-буулга, зорь-зорилго гэх мэт.

§ 43. Хамаатуулах -х дагаврыг эр, эм ямар ч үгэнд зөөлний тэмдэг буюу и үсэггүй бичнэ. Жишээлбэл: дараах, хойнох, доторх, гаднах, эндэх, манайх, манайхан, танай, дундах гэх мэт. Хааяа энэ дагавар өгөх оршихын тийн ялгалын нөхцөл зэрэгтэй нийлж тусгай үг мэт болсон байх учир бичгийн хэлний уламжлалыг дагаж дахь, дахин гэж тусгай бичнэ.

1.17. ЗАРИМ ТИЙН ЯЛГАЛЫН НӨХЦӨЛИЙГ БИЧИХ НЬ

§ 44. Зарим тийн ялгалын нөхцөлийг бичих тухай өгүүлбэл

1. Үгийг тийн ялгалаар хувилгахдаа тогтворгүй н үсгийг уг үгийн төгсгөлийн гийгүүлэгч гэж үзэхгүй, харин, үгийн үндэс ба залгаврын жийрэг гэж үзнэ. Жишээлбэл: тэрэг-тэ-рэгний, тө лөг-тө лөгний, үндэс-үндэсний гэх мэт.

2. Тогтворгүй н-тэй үгийг тийн ялгалаар хувилгахдаа н үсгийг гаргаж бичнэ. Энэхүү тогтворгүй н үсэг ихэвчлэн харьяалах, өгөх орших, гарах гурван тийн ялгалд нэгэн адил гарна. Жишээлбэл: модны, модонд, модноос, морины, моринд, мориноос, унины, унинд, унинаас гэх мэт. Гэтэл номны сан гэдэггүй учир номонд гэж бичихгүй номд, асуултны амжилтны гэдэггүй учир асуултад, амжилтад гэж бичнэ.

3. Харьяалахын тийн ялгалын -ы, -ий нөхцөлийг тогтвортой ба тогтворгүй н үсгээр төгссөн үгэнд эгшиг зохицох ёсоор залгана. Жишээлбэл: модны, түмний, усны гэх мэт. Харьяалахын тийн ялгалын -н нөхцөлийг хос эгшиг ба урт ий эгшгээр төгссөн үгэнд залгана. Жишээлбэл: толгойн, дэлхийн гэх мэт.

4. Өгөх оршихын тийн ялгалын нөхцөл -д,-т нөхцөлийг г ба өмнөө эгшигтэй с гийгүүлэгчээр төгссөн тогтворгүй -н гүй үгэнд залгана. Жишээлбэл: худагт, Нацагт, нутагт, хэлтэст гэх мэт. Бас р, в гийгүүлэгчээр төгссөн зарим үгэнд уламжлал баримтлан бичнэ. Жишээлбэл: гарт, Дэндэвт гэх мэт. -д нөхцөлийг дээрхээс бусад үсгээр төгссөн үгэнд бичнэ. Жишээлбэл: ахад, шилд, сард, хүн бүрд гэх мэт.

5. Заахын тийн ялгалын -г нөхцөлийг урт, хос эгшиг, хэлний угийн н үсгээр төгссөн үгэнд залгана. Жишээлбэл: дүнг, шороог, тахиаг, гахайг, Галсанг гэх мэт. Биеийн хамаатуулах минь, чинь, нь-ийн өмнөх заахын тийн ялгалын -ыг, -ийг, харьяалахын тийн ялгалын -ын, ийн, нөхцөлийн г, н үсэг, сонстохгүй боловч энэхүү н, г үсгийг гээхгүй бичнэ. Жишээлбэл: ахыг нь, гарыг минь, үзгийг чинь, гарын нь гэх мэт (ахы нь, гары минь, үзгий чинь, гары нь гэж бичвэл буруу).

6. Зарим нэр үг хоёр өөр утгыг илтгэх болоод тийн ялгалаар хувилахдаа ч ялгавартай болжээ. Жишээлбэл: Шөнө од (нэрлэхийн тийн ялгал) гялалзана. Алтан гадас одон Лувсангийн энгэр дээр гялалзана. Ард Насангийн соёолон насны морь наадамд түрүүлэв. Өвлийн эхэн сарын (харьяалах) арван тавны шөнө сарны гэрэл тооноор орно, сард авах цалин, саранд нисэж очих гэх мэт. Зарим үг тийн ялгалаар хоёр өөр хувирч хоёр өөр утгыг илтгэх явдал байна. Жишээлбэл: адуугаар баян нэгдэл, танай адуунаар миний морь явчлаа гэх мэт.

1.18. ҮЕИЙН ТУХАЙ, ҮГ ШИЛЖҮҮЛЭХ НЬ

§ 45. Амьсгалын нэг түрэлтээр хэлэгдэх нэг буюу хэдэн авиаг үе гэнэ. Үг, нэг түрэлтээр хэлэгдэх эгшгийн тоогоор үе болно. Урт ба хос эгшиг нэгжгээд үе болно. Жишээлбэл: ман-дуул-сан, хой-но, хойш-ло-ход, тэм-дэг-лэг-дэх-дээ, сурт-лаа-раа, хонь, торь, о-ё гэх мэт. Үгийг үелэхдээ:

1. Үелэх заагт нэг гийгүүлэгч байвал тэр гийгүүлэгчийн өмнүүр, хоёр гийгүүлэгч байвал хоёрдугаар гийгүүлэгчийн өмнүүр, гурван гийгүүлэгч байвал гуравдугаар гийгүүлэгчийн өмнүүр, дөрвөн гийгүүлэгч байвал дөрөвдүгээр гийгүүлэгчийн өмнүүр үелнэ. Жишээлбэл: го-лын, ол-дох, үлд-сэн, тө-рөлхт-ний гэх мэт.

2. Хатуугийн тэмдэг, зөөлний тэмдгийг өмнөх гийгүүлэгчийг дагуулан үелнэ. Жишээлбэл: үзь-е, ха-рууль-я гэх мэт.

§ 46. Нэг мөрөөс нөгөө мөрт үгийг шилжүүлэхдээ үеэр тасалж шилжүүлнэ. Нэг үеийг хоёр мөрт хувааж бичиж болохгүй. Хэдийгээр биеэ даасан үе боловч нэг үсгийг мөрийн эцэст үлдээх, буюу шинэ мөрт шилжүүлж болохгүй. Жишээлбэл: олох, явуулья, гэхэд тасалж шилжүүлж болохгүй. Тасалж шилжүүлсэн зураасыг зөвхөн мөрийн эцэст тавина.

1.19. ТОМ ҮСГЭЭР БИЧИХ НЬ

§ 47.

1. Өгүүлбэрийн эхний үсгийг заавал томоор бичнэ. Жишээлбэл: Манай эх орон уудам, ард түмэн нь эрх жаргалантай билээ. Бид энх тайвныг сахин хамгаална гэх мэт.

2. Хүний нэр, амьтан, хот суурин, уул ус зэрэг ертөнц дээр ижилгүй юмны оноосон нэрийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Дамдины Сүхбаатар, Улаанбаатар хот, Энх тайвны гудамж, Богд уул, Орхон гол. Шувуун саарал (морь), Банхар (нохой) гэх мэт.

3. Дэлхий дахины албан ба олон нийтийн байгууллагын нэрийг хэдэн үгээр бүтсэн бол цөмийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Нэгдсэн Үндэстний Байгууллага, Дэлхийн Энх Тайвны Зөвлөл, Эдийн Засгийн Харилцан Туслах Зөвлөл гэх мэт.

4. Улс гүрэн ба улсын төвийн хороо, зөвлөл, яам, холбоо зэрэг байгууллагын нэр хэдэн үгээр бүтсэн бол цөмийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хороо, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөл, Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, Монголын Хөгжмийн Зохиолчдын Холбоо, Ардын Боловсролын Яам гэх мэт. Үүнээс бусад улсын төвийн захиргаанд харьяалагдах албан, үйлдвэр, аймаг, сум район, соёл шинжлэх ухаан зэрэг газрын нэрийг хэдэн үгээр бүтсэн бол зөвхөн эхний үгийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн, Сэлэнгэ аймгийн Намын хороо, Ерөөгийн Сангийн аж ахуй, Ноосны үйлдвэрийн нэгдэл, Хүүхдийн хувцасны үйлдвэр гэх мэт. **Тайлбарлах нь:**

а) 47-р зүйлийн 3, 4-д заасан оноосон нэрийг дэлгэрэнгүй товч ямраар ч бичсэн том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Зөвлөлт Холбоот Улс, Зөвлөлт Улс, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл; Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл, Төв Зөвлөл, Их сургууль, Улсын Их сургууль, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Их сургууль гэх мэт.

б) Монгол, Орос зэргийн улс орны нэрийг зөвхөн хүний ерийн нэр болгож хэрэглэх буюу орон улсаас өөр эд юм ба ерийн нэр үгийн өмнө тодотгол болгож хэрэглэсэн бол бага үсгээр бичнэ. Жишээлбэл: Жижигхэн монгол эмээл моринд халтай. Бид орос суралцахыг оролдоно гэх мэт. Бас “монгол хэл” гэхэд бага үсгээр бичээд, “Монголын хэл” гэхэд том

үсгээр бичнэ. Учир нь монгол хэл гэхэд “монгол” бол зөвхөн тодотгол бөгөөд “ямар” гэсэн асуултад хариу болно. Монголын хэл гэдгийн “Монгол” бол орон улс нийтийг нэрлэж байгаа юм. Гэвч тэр монголын үс нь хар гэхэд монголыг жижиг үсгээр бичнэ. Учир нь энд Монгол улсыг хэлээгүй, зөвхөн нэг монгол хүнийг хэлж байна.

в) Том үсгээр бичигдвэл зохих хэдэн үгээр бүтсэн нэг юмны нэрийг товчилж аль нэг үгийг авч бичвэл түүнийг том үсгээр эхэлж бичихгүй. Жишээлбэл: Манай байгууллагын Монгол Ардын Хувьсгалт Намын гишүүд цуглав. Манайд намын хэдэн гишүүн цуглав. Монгол Ард Улсын төлөө зүтгэх, улсын төлөө зүтгэх гэх мэт.

5. Ном зохиол сонин сэтгүүл, нэгдэл зэргийн нэрийг хашилтад том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: В.И. Лениний “Юу хийх вэ” зохиолыг уншиж тэмдэглэл хөтөлбө. “Үнэн” сонин, “Ардын төр” сэтгүүл, Явуухулангийн “Мөнгөн хазаарын чимээ” зохиол. “Бүтээлч” нэгдэл гэх мэт.

6. Эрхэмлэн хүндэтгэсэн утгаар хэрэглэсэн зарим үгийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Жаран насны ойг тань тохиолдуулан Танд эрүүл энх, урт удаан наслахыг ерөөе. Даян дэлхийд Энх тайван мандтугай! гэх мэт.

7. Онцгой дурсгалт үйл явдлын нэрийг том үсгээр эхэлж бичнэ. Жишээлбэл: Октябрийн хувьсгал, Майн баяр гэх мэт.

8. Хамт бичиж заншсан хоёр үгнээс бүтсэн оноосон нэрийн хоёрдугаар үг нь эгшгээр эхэлсэн байвал хооронд нь холбоос тавьж хоёр дахь үгийг томоор эхэлж бичнэ. Жишээлбэл: Баян-Өлгий, Буян-Өлзий, Баруун-Урт хот гэх мэт.

1.20. ҮГ ХУРААЖ БИЧИХ НЬ

§ 48. Хэдэн үгээр бүтсэн нэг нэрийг хурааж бичиж болно.

1. Эхний үеэр хураана. Жишээлбэл: ня-бо (нягтлан бодох), тө. (төгрөг), мө. (мөнгө) гэх мэт.

2. Эхний үсгээр хураана. Жишээлбэл: МАХН, БНМАУ гэх мэт.

3. Заримдаа хоёр үгээр бүтсэн нэг нэрийг хураахдаа хоёр үгийн эхний үсгээр хураана. Жишээлбэл: БХ-Баянхонгор, УБ-Улаанбаатар гэх мэт.

4. Зарим үгийг эх адгийн үсгээр хурааж болно. Жишээлбэл: 18-р хурал, 5-р сар, н-р (нөхөр), д-р (доктор) гэх мэт.

5. Оноосон нэрийг үсгээр хураавал бүх үсгийг томоор бичнэ. Үеэр хураавал үеийн эхний үсгийг буюу бүх үсгийг томоор бичнэ. Хүний овог нэрээс бусад оноосон нэрийг хураасан үсгийн ард цэг тавихгүй. Жишээлбэл: МАХН, БНМАУ, ХЗХ (Хөгжмийн зохиолчдын холбоо), БНАфгУ (Бүгд Найрамдах Афганистан Улс), Мон Ца Мэ буюу МОНЦАМЭ, Д. Нацагдорж, Ц. Гайтав гэх мэт.

1.21. ГАДААД ҮГИЙГ БИЧИХ НЬ

§ 49. 1. Монгол хэлэнд эрт цагт орсон бөгөөд нийтэд гадаад үг гэж мэдэгдэхээ больсон үгийг монгол үсгийн дүрмийг баримталж бичнэ. Жишээлбэл: шил, эрдэнэ, цонх, янз, судар, саван, савхи, булигаар гэх мэт.

2. Ойрмог гадаад хэлнээс аваад гадаад үг гэдэг нь нийтэд мэдэгдэж байгаа үгийг бичихэд уг хэлний дуудлага ба бичгийн дүрсийг харгалзана. Орос үг ба оросоор дамжиж ирсэн гадаад үгийг оросоор яаж бичдэгийг ерөнхийд нь баримталж бичнэ. Жишээлбэл: мотор, феодал, трест, трактор, большевик, артель гэх мэт.

3. Гадаад үг бол монгол хэлний эгшиг зохицох ёс, балархай эгшигийн дүрэм ба гээгдэх эгшигийн дүрмийг дагахгүй.
4. Оросоор ия үсгээр төгссөн үгийн эцсийн ия үсгийг ия төлөв хасна. Жишээлбэл: Румыния-Румын, станция-станц, комиссия-комисс, лекция-лекц гэх мэт. Гэвч ия үсгээр төгссөн зарим үгийн эцсийн гийгүүлэгч зөөлөрсөн байвал зөвхөн я үсгийг хасна. Жишээлбэл: Азия-Ази, Италия-Итали гэх мэт. Гадаад үгийн эцэст өргөлтгүй богино эгшиг байвал түүнийг их төлөв хасна. Жишээлбэл: фабрика-фабрик, апте-ка-аптек, норма-норм, тонна-тонн гэх мэт. Хэрэв гадаад үгийн эцсийн эгшиг өргөлттэй бол хасаж болохгүй. Жишээлбэл: кино, пальто, шевро гэх мэт.
5. Гадаад үгэнд монгол хэлний залгавар залгаж болно. Гадаад үгэнд ямар нэг эр эгшиг байвал эр үгийн залгавар залгана. Нэг үгэнд хэд хэдэн өөр эр эгшиг байвал аль өргөлттэй эгшигт нь зохицуулан залгавар залгана. Хэрэв эр эгшиг дээр өргөлт ногдоогүй бол эхний эр эгшигт зохицуулан залгавар залгана. Жишээлбэл: аптекаар, пионерын, театрууд, бригадад, механикжсан, автобуснаас, ацетоны гэх мэт. Хоёр үгнээс бүтсэн нэг нэрийн сүүлчийн үгийн эгшигт зохицуулан залгавар залгана. Жишээлбэл: агротехникээр, шмперметрийн, атмосферээс гэх мэт.
- Гажилт:**
Зарим үгийн төгсгөлийн өргөлтөт эр эгшиг балархай хэлэгдвэл монгол хэлний уламжлал ёсоор нэгдүгээр үеийн эгшигтэй зохицуулан эгшиг бичиж болно. Жишээлбэл: кило-килээр, килтэй, киллэвэл, киллэнэ гэх мэт.
6. Гадаад үгэнд ямар нэг эр эгшиг байхгүй бол эм үгийн залгавар залгана. Жишээлбэл: хими-химийс, лент-лентээр, шеф-шефийн, трест-трестүүд гэх мэт.
7. К үсгийг хэлний г үсгийн дүрмээр к үсгээр төгссөн эр үгэнд ий эгшиг залгах ба к үсгийг эгшигт гийгүүлэгчийн адил үзэж залгавар залгана. Жишээлбэл: фабрикийн, паркт, тактикла гэх мэт. Мөн щ үсгийг ш үсгийн адил үзэж зохих залгавар залгана.
8. Б, п, ф, в үсгийг нэг төрлийн үсэг гэж адилаар үзнэ. Жишээлбэл: Ямар драп бэ? Хэний шкаф бэ? Хэдэн куб бэ? шкафт, клубт гэх мэт.
9. Оросын у үсгийг монголын ү үсгийн адил эм эгшиг гэж үзэж залгавар залгана. Жишээлбэл: клубээс, группийн гэх мэт.

1.22. СУЛ ҮГ, ДАГАВАР ҮГИЙГ ЗӨВ БИЧИХ НЬ

§ 50. Сул үгийг уг үгнээс нь саланги бичнэ.

1. Асуух сул үг бэ, вэ заримдаа урт эгшигтэй, заримдаа эгшиггүй хэлэгдэх боловч вээ, в хоёр хэлбэрийг хэрэглэхгүй, дандаа бэ, вэ гэж богино эгшигтэй бичнэ. Жишээлбэл: Таны нас хэд вэ? Та хэзээ буцах вэ? Хэн хэлэх вэ? В, л, м, н үсгээр төгссөн үгэнд бэ бичнэ. Жишээлбэл: Яасан их ов бэ? Ямар өргөн гол бэ? Аль аймгийн ямар сум бэ? Өнөөдөр хэдэн бэ? гэх мэт. Үүнээс бусад эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд вэ бичнэ. Жишээлбэл: Ямар газар вэ? Хэний хонь вэ? Хэн хэлэх вэ? Одоо яах вэ? (яахав гэж бичиж болохгүй) гэх мэт.
2. Асуух сул үг юу, юү хоёрыг урт ба хос эгшгээр төгссөн үгэнд эгшиг зохицох дүрмээр бичнэ. Жишээлбэл: Адуу юу, тэмээ юү? Малгай юу? бээлий юү гэх мэт. Үүнээс бусад богино эгшиг гийгүүлэгчээр төгссөн үгэнд уу, үү бичнэ. Жишээлбэл: хана уу, унь уу, тэрэг үү, чар-га уу гэх мэт.
3. Л, ч, шүү сул үгийг ямар ч үгийг дагуулан саланги бичнэ. Жишээлбэл: Сайн л явна. Өвс ч их ургажээ. Тоогоо бодно шүү гэх мэт.
4. Зөвшөөрөх сул үг за-г богино эгшигтэй бичнэ.

5. даа, дээ, доо, дөө сул үгийг эгшиг зохицох дүрэм баримтлан саланги бичнэ. Жишээлбэл: авна даа, хэлнэ дээ, олно доо, өгнө дөө гэх мэт.

6. Дуудах аялга үг аа, ээ, оо, өө дөрвийг эгшиг зохицох дүрмийг баримтлан саланги бичнэ. Жишээлбэл: хүүхдүүд ээ, залуучууд аа, нөхөд өө гэх мэт.

7. Дагавар үг уруу гэж бичихдээ эгшиг зохицуулахгүй эхний эгшгийг хасахгүй эр эм ямар үгэнд уруу хэвээр нь бичнэ. Жишээлбэл: уул уруу (уул өөд гэдэгтэй адил), тэр уруу (гэр өөд гэдэгтэй адил), гол уруу, өрөө уруу гэх мэт. Уул руу, гэр лүү гэж бичихгүй.

8. Идэвхгүй “а” язгуур нь гээгдсэн “сан, даг” нөхцөлийг ур үгнээс нь саланги эгшиг зохицох дүрмийн ёсоор сан, сэн, сон, сөн, даг, дэг, дог, дөг гэж бичнэ. Жишээлбэл: явсан сан, явсан даг, ирдэг сэн, ирдэг дэг, очсон сон, очсон дог, өгсөн сөн, өгсөн дөг, хардаг сан, хардаг даг, мэддэг сэн, мэддэг дэг гэх мэт.

9. Тэрчлэн мэтчилэн энэчлэн, сэтгэлчлэн зэрэг чилэн залгаврыг балархай эгшгийн дүрэм, эгшиг зохицох ёсоор уг үгтэй нь хамт бичнэ. Жишээлбэл: түүнчлэн, явдагчлан, явсанчлан гэх мэт.

1.23. ЦЭГ, ЦЭГЛЭЛ

1.23.1. Цэг

§ 51. (.)

а) Хүүрнэсэн өгүүлбэрийн эцэст цэг тавина. Жишээлбэл: Нар гарав. Монгол хүн сансарт нисэв гэх мэт.

б) Ерийн байдлаар захирсан өгүүлбэрийн эцэст мөн цэг тавина. Жишээлбэл: хүү минь, хичээлээ давт. Дараа нь хоолоо ид.

в) Тооны тэмдгийн ард цэг тавьж дугаар гэсэн утгыг илэрхийлнэ. Жишээлбэл: 1. Хичээл (нэгдүгээр хичээл), 10. Бүлэг (аравдугаар бүлэг), 5. Дасгал (тавдугаар дасгал) гэх мэт.

г) Цэгийг үг хураасныг заахад хэрэглэнэ. Жишээлбэл: Д. Сүхбаатар, Х. Чойбалсан, Г. Бумцэнд гэх мэт. Тэмдэглэх нь Номын нэр, бүлэг гарчиг, албан газрын хаяг зэргийг том үсгээр эхэлж бичих боловч эцэст нь цэг тавихгүй.

1.23.2. Асуултын тэмдэг

§ 52. (?)

а) Асуусан өгүүлбэрийн эцэст асуултын тэмдэг тавина. Хэрэв асуусан утгатай хэд хэдэн үг, өгүүлбэр дараалан орвол тэрхүү үг өгүүлбэр тус бүрд асуултын тэмдэг тавьж болох ба эсвэл өгүүлбэрийн хооронд таслал тавьж өгүүлбэрийн эцэст асуултын тэмдэг тавьж болно. Жишээлбэл: Энэ номыг та уншсан уу? Үгүй юу? Уншсан бол танд ямар санагдав? Энэ номыг та уншсан уу, үгүй юу уншсан бол танд ямар санагдав? гэх мэт.

б) Иш татсан зүйлд зарим нь эргэлзээтэй буюу бүрхэг санагдвал өгүүлбэр дотор асуултын тэмдгийг хаалтад тавьж болно. Жишээлбэл: Доржийн хэлсэн нь: “Бэлчээрийн өвсний сөлтэй эсэхийг мэдэхийн тулд хэдэн ширхэг өвсийг шатааж үзэх хэрэгтэй. Өвс шатаад хар өнгөтэй болбол сөлтэй байна. Хөх өнгөтэй өвс (?) бол сөлгүй байна” гэх мэт.

в) Бусдын шууд асуусан үгийг өгүүлбэрийн дотор оруулан бичихэд мөн асуултын тэмдэг тавина. Жишээлбэл: Багш сурагчдаас “Хичээлээ бэлтгэсэн үү?” гэж асуугаад сурагчдын бэлтгэсэн даалгаврыг шалгаж эхлэв гэх мэт.

1.23.3. Анхаарлын тэмдэг

§ 53. (!)

- а) Сэтгэл ихэд хөдлөн хэлсэн (анхааруулах) өгүүлбэрийн эцэст анхаарлын тэмдэг тавина. Жишээлбэл: МАХН мандтугай! Онгоц ирлээ ээ! гэх мэт.
- б) Сэтгэл ихэд хөдөлж хэлсэн хандсан үг, аялга үгийн дараа анхаарлын тэмдэг тавина. Жишээлбэл: Нөхөд өө! Таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлцгээе! Ээ гялай! Манай бригад түрүүлжээ!

1.23.4. Цуваа цэг

§ 54. (...)

- а) Өгүүлбэр төгсөөгүй буюу өгүүлбэрийн дунд хэлэлгүй орхисон үгийн оронд цуваа цэгийг тавина. Жишээлбэл: Нэг хүн: Аливаа жижиг юмыг урьд хар хумсны төдий гэж зүйрлэдэг байсан. Энэ зүйрлэл одоо ... гээд хэлэх гэтэл нөгөө хүн: Тэр зүйрлэл хуучирчээ гэж хэлэв гэх мэт.
- б) Үг өгүүлбэр төгссөн боловч зохиогч санаагаа бүрэн гаргаж чадаагүй дутуу орхисон гэж үзвэл цуваа цэгийг тавина. Жишээлбэл: Би чоныг хөөж явтал чоно жалга уруу оров ... гэх мэт.
- в) Мэгдэж түгдэрсэн буюу ээрч түдгэлзсэн газарт цуваа цэгийг тавина. Жишээлбэл: Юу ... юунд ... шатаах билээ. Миний бод ... бодвол эндхийн ар ... ард о ... олонд тар ... тарааж өг ..., өгвөл зүй ... зүйтэй гэж хэлмэгц ... (Н. А. Остроеский, “Болд хэрхэн хатагдсан нь” зохиолоос) гэх мэт.
- г) Иш татсан зүйлд энд тэндээс орхисон бол тэр орхисон газрыг цуваа цэг тавьж тэмдэглэнэ. Жишээлбэл: 1925 онд Монголын сэхээтэнд илгээсэн захидалдаа М. Горький бичсэн нь: ... Идэвхтэй зарчим, ухааны шаргуу ажиллагааг илүү үзүүлсэн бөгөөд үргүй чөлөөг хүсэх биш, харин, жинхэнэ эрх чөлөөг хүссэн зүйлийг ... өргөнөөр харуулсан зохиолыг орчуулах нь чухал гэж сургамжилсан юм гэх мэт.
- д) Шүлгийн мөрүүдийг орхисон буюу үргэлжилсэн зохиолын том бүлэг, их хэсгийг орхисныг үзүүлэх гэвэл цуваа цэгийн оронд мөрлөсөн цэгийг тавина.

1.23.5. Давхар цэг

§ 55. (:)

- а) Аливаа хүний хэлсэн үг, бодсон санаа зэргийг бичихдээ өмнө нь өгүүлэгч, бодогч эзний дараа давхар цэг тавиад ур хөндлөнгийн үгийг хашилтад бичнэ. Жишээлбэл: Багш: “Хичээлээ эхэлье” гэж сурагчдад хэлэв. Давхар цэгийн дараа хашилтын оронд урт зураасыг хэрэглэж болно. Ингэвэл гол төлөв догол мөрөөс эхэлж бичнэ. Жишээлбэл: Багш: "Хичээлээ эхэлье" гэж сурагчдад хэлэв.
- б) Аливаа тоочин хэлэх зүйлийн өмнө хамтатгасан буюу угтсан утгатай (жишээ нь, жишээлбэл, тухайлбал, үлгэрлэвэл, нэрлэвэл зэрэг үг байвал давхар цэг тавина. Жишээлбэл: Шууд тусагдахуун авч чадах бүх үйл үгийг тусах үйл үг гэнэ. Жишээлбэл: Би бичиг уншия. Бид таны морийг авчрав гэх мэт. Шууд тусагдахуун авч үл чадах үйл үгийг эс тусах үйл үг гэнэ. Жишээлбэл: Бид мориор ирэв. Ард түмэн жаргав гэх мэт.

1.23.6. Таслал

§ 56. (.)

Таслал тавихгүй бол өгүүлбэрийн утга хувирах буюу бүрхэг болох газарт таслал заавал тавина. Таслалыг хэрэглэх нь:

а) Зэрэгцсэн гишүүн хэд хэдэн үг, хоршоо үгээр бүтсэн бөгөөд таслал тавихгүй бол утга бүрхэгдмээр байвал хооронд нь таслал тавина. Жишээлбэл: Талд олон хонь, цөөн адуу, хэдэн үхэр бэлчиж байна. Хойд авдрыг нээвэл: Хуйгаар торго, хунзаар цай, хулсан лимбэ, хуур ятга, бийр ян-тай, бичиг данс, шагай шатар, хашлага сум, эрийн зодог, эвийн цавуу, хурдан морины хусуур, хур сүүлийн боолт хүртэл цөм бүрэн, түүнийг мялаая гэх мэт. Хэрэв зэрэгцсэн зарим гишүүд нь нэг үгээр ба хэд хэдэн үгээр холилдон бүтсэн бол нэг үгээр бүтсэн зэрэгцсэн гишүүнийг таслалгүй бичиж болно.

б) Таслалыг урт өгүүлбэрийг хэсэглэн уншихын тул бичих ба бас нөхцөл үйл өгүүлэхүүн нь өмнөх хойдох аль үгэнд холбогдож байгааг харуулахын тул тавина. Жишээлбэл: Дарга ирж, байгаа хүмүүсийг хуралдуулав. Дарга-ирж байгаа хүмүүсийг хуралдуулав. Арслан-Туулын хөвөөнд очоод, усанд орж байгаа Дуламтай дайралдав. Арслан-Туулын хөвөөнд очоод усанд орж байгаа Дуламтай дайралдав. гэх мэт.

в) Зарим дэд гишүүн нь дараагийн үгэнд шууд холбогдохгүй нэг буюу хэдэн үгийг алгасаж өөр үгэнд холбогдох бол таслал тавина. Жишээлбэл: Өчигдөр, таны авчирсан номыг уншив. Өчигдөр таны авчирсан номыг уншив. Модчин-Хэнтийн салбар уулнаас мод огтлох, цахилгаан хөрөөгөөр банз зүсэх, сүүний заводод хэрэглэх торх хийх зэрэг ажлыг хийж байна. Үүнд:огтлох, зүсэх, хийх зэрэг үг нь ажлыг гэдэг үгийн тодотгол бөгөөд таслалгүй бол огтлох нь цахилгааны тодотгол, зүсэх нь сүүний тодотгол шиг болно.

г) Нийлмэл өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйлт нэр буюу нэр үгийн аймгийн үг байвал дараах үгийн тодотгол мэт болох учир таслал тавина. Жишээлбэл: Нэгдлийн хонийг би өчигдөр хариулсан, аав өнөөдөр хариулаад сая ирсэн, ижий маргааш хариулна гэх мэт.

д) Өгүүлбэрийн төгс өгүүлэхүүний дараа дэд гишүүн орвол хооронд нь таслал тавина. Жишээлбэл: Би авлаа шүү, энэ номыг чинь гэх мэт.

е) Хандсан үг, оруулсан үг, аялга үгийг өгүүлбэрийн эхэнд бичвэл ард нь, дунд бичвэл хоёр талд нь, эцэст бичвэл өмнө нь таслал тавина. Жишээлбэл: Хөгшин ижий нь, бусдаас сонсоход, охиноо мөрөөдсөөр өвчтэй болох шахаж гэнэ. Охин нь, сээтгэнүүр гайхал, эхдээ нэг ч захидал бичээгүй хоёр жил боллоо. Би ногоотой хоолонд махнаас илүү дуртай, үнэнээ хэлэхэд гэх мэт.

Таслалыг сайн бодож оновчтой тавихгүй бол өгүүлбэрийн, утгыг тодорхой болгохгүй, харин ч, бүрхэг болгож таслал тавьсан тавиагүй хоёр адилхан болно. Жишээлбэл: Дондог ууланд гарч жимс түүж яваад хүйтэн бороонд нэвт норж чичирч байгаа хүүхдийг үзэв гэсэн энэ өгүүлбэрийн нөхцөл үйл үг бүрийн ард таслал тавивал дөрөв таван янзаар ойлгогдох болно. Хэрэв гарч гэдгийн ард таслал тавивал Дондог ууланд гарч яваад хүүхдийг үзсэн ба тэр хүүхэд жимс түүж яваад бороонд бороод чичирч байсан тухай өгүүлжээ. Энэ мэт нэг таслалыг түүж яваад гэдэг үгийн дараа тавихад өөр утгатай болно.

1.23.7. Цэгтэй таслал

§ 57. (.)

а) Таслалтай олон зэрэгцсэн гишүүнийг утгаар нь ангилахын тул цэгтэй таслал хэрэглэнэ.

Жишээлбэл: Ертөнц гэхэд: газар дээрх уул ус, шороо чулуу; хүн амьтан, мод ургамал, ан гөрөөс цөм орно.

б) Өгүүлбэрийн зэрэгцсэн олон гишүүн нь тоо дугаартай боловч бүтэн өгүүлбэр биш байвал эцэст нь цэгтэй таслал тавина. Жишээлбэл: Орон сууц хөлслөн авагчид нь:

1. Орон сууц ашигласны хөлсийг цаг тухайд нь төлөх, хэрэв гэрээнд өөрөөр заагаагүй бол орон сууцны хөлсийг сар тутам, дараа сарын 10-наас хожимдуулах-гүй төлөх;
2. Орон сууцыг зохих зорилго гэрээний нөхцөлд зохицуулан ашиглах, эвдрэл гэмтэлгүй байлгах, орон сууц, нийтийн ашиглалтын газрын ариун цэврийг сахих
3. Орон сууцанд зайлшгүй шаардагдах бага засварыг цаг тухайд нь хийх;
4. Хамтын аж байдлын социалист хэв журмыг сахиж орон нутгийн ардын депутатуудын хурал, улс хоршооллын олон нийтийн байгууллагын мэдлийн орон сууцыг ашиглах (орон сууцны дотоод дүрэм) дүрмийг сахим биелүүлэх, үүрэгтэй. (Иргэний хуулийн 202-р зүйлээс).

в) Хэлбэрийн хувьд биеэ даасан өгүүлбэрүүд утгын хувьд нягт холбоотой байвал хооронд нь цэгтэй таслал тавина. Жишээлбэл: Манай аргал бороонд их норжээ; нар гараасай аргал хатах сан.

1.23.8. Хашилт

§ 58. (« » “ ”)

а) Шууд хэлсэн хөндлөнгийн үгийг хашилтад хийнэ. Жишээлбэл: 1846 онд Карл Марксын хэлсэн нь “Хөгжлийн явцад ажилчин анги хуучин хөрөнгөтөн нийгмийн оронд ангиуд ба эдгээрийн зөрчлийг арилгасан тийм эвлэлийг бий болгоно. Чухамдаа улс төрийн ямар ч засаггүй болно” гэх мэт.

б) Аливаа үгийг ерийн утгаар биш, онцлон заасан буюу егөөдсөн утгаар хэрэглэвэл хашилтад хийнэ. Жишээлбэл: Мөн ч “гавшгай” ажилладаг хүн байна даа гэх мэт. Үүнд “гавшгай” гэсэн нь чухамдаа гавшгай биш гэсэн санааг илтгэжээ.

в) Ном зохиол, сонин сэтгүүл, онгоц хөлөг, үйлдвэр нэгдэл, албан байгууллага зэргийн болзож оноосон нэрийг их төлөв хашилтад хийнэ. Тэмдэглэх нь:

1. Дээр дурдсан зүйлийн ерийн нэрийг хашилтгүй бичнэ.
2. Зохиолын зүүлт ба номын бүртгэлд зохиолын нэрийг зохиогчийн нэрийн хойно хашилтгүй бичнэ.
3. Олонд алдаршсан зарим ном сонин зэргийн оноосон нэрийг заримдаа хашилтгүй бичнэ. Жишээлбэл: Намын Үнэн сонин, Монголын Нууц товчоо, Гэсэрийн тууж гэх мэт.

1.23.9. Хаалт

§ 59. () []

а) Дүгрэг хаалт, дөрвөлжин хаалт гэж хоёр зүйлийн хаалт хэрэглэнэ. Өгүүлбэрийн дотор тайлбар тодорхойлолт нэмэлт ажиглалт зэрэг үг өгүүлбэрийг хаалт дотор бичиэ.

Жишээлбэл: Ардын Хувьсгалт Намын үйл хэргийг биелүүлэхэд ардын сайн дурын олон байгууллага (залуучуудын эвлэл, үйлдвэрчний эвлэл, пионерын байгууллага зэрэг) туслалцана гэх мэт.

б) Илтгэгчийн үгийг сонсогчид ямраар үзсэн, яасан тухай тэмдэглэлийг хаалтад бичнэ.

в) Дүгрэг хаалтыг өмнөх үгийн тайлбар болгож хэрэглэдэг бол дөрвөлжин хаалтыг нэмэлт оруулга үгэнд хэрэглэнэ. Жишээлбэл: Гадаад хэлийг гэнэт дайрч [хэдхэн хоногийн дотор] сурахад хэцүү, харин, тогтмол чармайвал сурахад хялбар гэх мэт.

1.23.10. Зураас

§ 60. (- --, —)

Богино зураас, урт зураас, таслалтай зураас гэж гурван янзын зураас хэрэглэнэ. Богино зураасыг хэрэглэх нь:

а) Үгийн хагасыг нөгөө мөрт шилжүүлэхэд мөрийн эцэст үлдсэн хагас үгийн ард богино зураасыг тавина.

б) Олон хэрэглэдэг зарим үгийг эх адгийн үсгээр хураахад богино зураас тавина.

Жишээлбэл: Доктор д-р, нөхөр н-р, 10-р гэх мэт.

1.23.11. Урт зураас

§ 61. —

а) Өгүүлэгдэхүүний илтгэцийн үүргээр хэрэглэнэ. Жишээлбэл: Багш Дорж—Дулам Зоригт нарт шинэ дуу заав. Говийн тэмээ адуу хонь ямаа—сарлагийг хараад үргэдэг юм гэх мэт.

б) Өгүүлэгдэхүүн гишүүн өгүүлбэр илтгэцгүй байвал урт зураас тавина. Жишээлбэл: Зуны ид халуун цаг—долдугаар сар гарлаа гэх мэт.

в) Нийлмэл өгүүлбэрийн нэг нь нөгөөгийн шалтгаан үр дагавар нэмэлт дүгнэлт чанартай бол хооронд нь урт зураасыг тавьж болно. Жишээлбэл: Уулыг өндөр гэж бүү ай—давъя гэвэл давна. Усыг гүн гэж бүү ай—гаталъя гэвэл гатална гэх мэт.

г) Цаг, зай, тооны хязгаарыг нэрлэсэн хоёр үгийн хооронд урт зураас тавина. Жишээлбэл: XV—XX зууны үе (15-аас 20-р зууны үе), Улаанбаатар—Москва хүрэх зам (Улаанбаатараас Москва хүрэх зам) 10—20 төгрөг (арав хорин төгрөг) гэх мэт.

1.23.12. Таслалтай зураас

§ 62. Зараа, сохор номин зэрэг шавж идэгчид; хэрэм минж туулай хулгана зэрэг мэрэгчид; чоно баавгай бар суусар зэрэг араатан; үхэр хонь ямаа буга гахай зэрэг ац туурайтан; морь илжиг зэрэг битүү туурайтан, - цөм сүүн тэжээлт амьтан болно.

1.23.13. Зүйлийн тэмдэг

§ 63. (§) Дүрэм, заавар, ном зохиолд § гэсэн зүйлийн тэмдгийг хэрэглэнэ. Жишээлбэл: § 65 гэснийг 65-р зүйл гэж уншина. Эсвэл зүйл 65" гэж уншиж болно.

1.23.14. Дэс дарааллыг тэмдэглэх нь

§ 64. Аливаа тоочсон зүйлийн дарааллыг тоогоор буюу цагаан толгойн үсгээр дугаарлаж бичнэ. Хэд хэдэн давхар дарааллыг тэмдэглэхдээ эхлээд ром тоогоор, түүний доторх дураарлалын тоог бичгээр мөн цифрээр, цагаан толгойн үсгийн дарааллаар тус тус дугаарлана.

Ром тоог зөвхөн дэс дараалал заахад хэрэглэх бөгөөд цэггүй бичнэ. Жишээлбэл: XVIII их хурал, XX зуун, V бүлэг гэх мэт.

Дугаар гэсэн үгийн оронд номерын тэмдэг №-ийг хэрэглэж болно. Жишээлбэл: Энэ хүний паспорт болбол 1983 онд олгосон № 272505 гэсэн номертой болно.

2. Нэмэлт өөрчлөлт (2011 он)

Тогтоол

Монгол улс төрийн хэлний зөвлөл

2011 оны 10 сарын 05 өдөр
дугаар №01

Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох тухай

“Төрийн албан ёсны хэлний тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.16 дахь хэсэг, ”Соёлын тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг. Кирил бичгийн бичлэгийн стандарт тогтоох мэргэжлийн комиссын дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

Кирил бичгийн бичлэгийн стандартыг тогтоосон монгол болон гадаад хэлний үгсийг 1,2 дугаар хавсралтын ёсоор, гадаад үгсийн монгол орчуулгыг 3 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

Бичлэгийн стандартыг тогтоосон үгсийг албан бичиг болон олон нийтэд зориулсан бүх төрлийн ном, сурах бичиг, мэдээлэл, хаяг, шошгод мөрдөн хэрэглэж байхыг төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакциуд, ном хэвлэдэг байгууллага, бүх шатны сургуулийн багш нар, тэдгээр сургуулийн сурах бичгийг зохиогчид, хянан тохиолдуулагч нар, зар сурталчилгааны агентлагуудад үүрэг болгосугай.

Бичлэг болон орчуулгыг тогтоосон үгсийг товхимол болгон хэвлүүлж, төрийн болон төрийн бус байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн редакциуд, ном хэвлэдэг байгууллага, бүх шатны сургуулийн багш нар, тэдгээр сургуулийн сурах бичгийг зохиогчид, хянан тохиолдуулагч нар, зар сурталчилгааны агентлагууд, төв болон орон нутгийн номын сангуудад зохих үнээр худалдан хүргэхийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын газар (Д.Эрдэнэчимэг), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (С.Наранцогт) -т даалгасугай.

Монгол хэлний дэлгэрэнгүй болон хураангуй тайлбар толиуд, олон хэлний толиудад байгаа үгсийн бичлэг, бүрэлдэхүүнийг тогтоосон стандартын дагуу хянаж, шаардлагатай өөрчлөлт хийж, хэвлэхийг толь зохиогчдод үүрэг болгосугай.

Дарга Ё.Отгонбаяр

2.1. Журамласан монгол үгс

2.1.1. А-Г

Хувилбарууд	Журамласан жагсаалт
аварга / аврага	аварга
авлига / авилга	авлига
авахуул / авхуул	авхуул
авьяас / авьяас	авьяас
аугаа / агуу	агуу
адсага / адасга	адасга
азрага / азарга	азарга
азгүйтэх / азгүйдэх	азгүйдэх
айлдвар / айлдал	айлдвар айлдал
айхтар / айхавтар	айхавтар
алив / аливаа	аливаа
алцаганах / алцганах	алцганах
амирлангуй / амарлингуй	амарлингуй
аравгар / арвагар	арвагар
аривлах / арвилах	арвилах
арзагар / арзгар	арзгар
аяандаа / аяндаа	аяндаа
бадируун / бадриун	бадриун
байгал / байгаль	байгаль
байцаа / байцай	байцай
баньд / банди	банди
бахирах / бархирах	бархирах
билиг / билэг / бэлгэ / бэлэг	билиг (оюун билиг) бэлгэ (бэлгэ тэмдэг) бэлэг (бэлэг дурсгал)
бич / мич	бич
бодгаль / бодьгал	бодгаль

бодос / бодис	бодис
бодот / бодит	бодит
бодьсад / бодисад	бодисад
борви / борив	борви
бохирдох / бохиртох	бохирдох (хиртэх) бохиртох (хөл хөших)
бөгөөд / бөгөөс	бөгөөд
бөгцгөнөх / бөгцөгнөх	бөгцгөнөх
бөндгөнөх / бөндөгнөх	бөндгөнөх
бувтнах / бувтанах	бувтнах
будлих / будилах	будилах
бургилах / буриглах	бургилах
бусниулах / бушнуулах	бусниулах
бүгчим / бөгчим	бүгчим
бүжин / бөжин	бөжин
бүжиглэх / бүжих	бүжиглэх бүжих
бүлтгэнэх / бүлтэгнэх	бүлтгэнэх
бүлэг / бөлөг	бүлэг
бүрчлэн / бүрчилэн	бүрчлэн
бүрэлдэхүүн / бүрэлдхүүн	бүрэлдэхүүн
бэлчир / билчир	бэлчир
бэлэвсэн / бэлбэсэн	бэлэвсэн
бэнчин / бинчин	бэнчин
бэртэнгэ / бэртэнги	бэртэнгэ
вандан / бандан	вандан (хадаг) бандан (ширээ)
гавж / гавьж	гавж
гавьяа / гавьяа	гавьяа
гадарга / гадрага / гадаргуу	гадарга гадаргуу
гаднах / гаднахь	гаднах
гайхшрал / гайхширал	гайхширал

гамин	гамин
ганьхрал / ганихрал	ганьхрал
гараг	гараг
гарваль / гарвал	гарваль
гарди / гарьд	гарди
гацуур / гачуур	гачуур (модны нэр) гацуур (мөчир)
гогодох / гогдох	гогодох
голдрил / гольдрол	голдрил
голдуу / голцуу	голдуу
гоньд / гонид	гоньд
гоолиг / гуалиг	гоолиг
гуаш / гуашь	гуаш
гулжгар / гулзгар	гулжгар (зөөлөн биеийн мурийсан байдал) гулзгар (хатуу биеийн мурийсан байдал. жишээ нь төмөр)
гуньхрах / гунихрах	гуньхрах
гурви / гурив	гурви
гүвгэнэх / гүвэгнэх	гүвгэнэх
гэгээлэг / гэгээлиг	гэгээлэг
гэр лүү / гэрлүү	гэр лүү

2.1.2. Д-Н

Хувилбарууд	Журамласан жагсаалт
давлагаалах / давалгаалах	давалгаалах
давилуун / давлиун	давлиун
давхарга / давхрага	давхарга
дайчилгаа / дайчлагаа	дайчилгаа

далдирах / дальдрах	дальдрах
дамжилга / дамжлага	дамжлага
дараах / дараахи	дараах
дарвагар / даравгар	дарвагар
даяаршил / даяарчлал	даяаршил даяарчлал
дийлэнх / дийлэнхи	дийлэнх
довтолгоо / довтлогоо	довтолгоо
долдугаар / долоодугаар	долоодугаар
долоодахь / долоодох	долоо дахь
доорх / доорхи	доорх
дооших / дооши	дооших
дор / доор	доор (байр заана) дор (чанар заана)
дорвитой / доривтой	дорвитой
дорнод / дорнот	дорнод
доторх / доторхи	доторх
дотуурх / дотуурхи	дотуурх
дөрөвдэх / дөрөвдөх	дөрөв дэх
дугариг / дугараг	дугариг
дужигнах / дужгинах	дужигнах
дуржигнах / дуржгинах	дуржигнах
дундад / дундат	дундад
дундах / дундахь	дундах
дундаж / дундач	дундаж
дурдах / дурьдах	дурдах
дуртгал / дурдатгал	дуртгал
дуугарах / дугарах	дуугарах
дуурайх / дууриах	дуурайх
дуурсах / дуурьсах	дуурьсах
дүйчин / дүүчин	дүйчин
дүл / дөл	шөнө дүл

дэгдгэнэх / дэгдэгнэх	дэгдгэнэх
дэгдээхий / дэгдээхэй	дэгдээхий
дэрчгэнэх / дэрчигнэх	дэрчгэнэх
дээрх / дээрхи	дээрх
дээших / дээшихи	дээших
есдэх / есдөх	ес дэх
ёнхгор / ёнхигор	ёнхгор
жайжганах / жайжигнах	жайжганах
жигжгэрэх / жижигрэх	жигжирэх
жирвэгэнэх / жирвэгнэх	жирвэгэнэх
жирвэгэр / жирэвгэр	жирвэгэр
жүрж / зүрж	жүрж
жүүс / шүүс	шүүс
зааварчилгаа / зааварчлагаа	зааварчилгаа
завж / завьж / жавж	завж
завьяа / завьяа	завьяа
загатнах / загтнах	загатнах
замбуутив / замбатив	замбуутив
зангилаа / зангилгаа	зангилаа, зангилгаа
засаршгүй / засрашгүй	засаршгүй
зовних / зовинох	зовних
зовуурь / зовиур	зовуурь
зогсонги	зогсонги (эр үгэнд -нги, эм үгэнд эгшиг зохицох ёсны дагуу нгө, нгэ дагавар залгана)
зогьсох / зогисох	зогьсох
зожиг / жожиг	зожиг
зөвлөлдөх / зөвөлдөх	зөвлөлдөх
зөвлөгөөн / зөвлөлгөөн	зөвлөгөөн
зөвлөгөө / зөвлөлгөө	зөвлөгөө
зугтах, зугатах	зугтах
зургадугаар / зургаадугаар	зургаадугаар
зууван / зуйван	зууван

зүдүүр / зүдгүүр	зүдүүр
зүүнтээгүүр / зүүнтэйгүүр	зүүнтээгүүр
идэвх / идэвхи	идэвх
илаарьших / илаарших	илаарьших
ирвэгэнэх / эрвэгэнэх	ирвэгэнэх (одод ~) эрвэгэнэх (биетийн дээш чиглэсэн давтагдах хөдөлгөөн)
иржигнэх	иржигнэх (дуу авиа давтагдах үйл)
иржгэнэх / эржигнэх	иржгэнэх (дүр төрх давтагдах үйл)
ирмүүн / эрмүүн	эрмүүн
исгэлэн / эсгэлэн	исгэлэн
исгэх / эсгэх	исгэх
исэх, эсэх	исэх
ихэвчлэн / ихэвчилэн	ихэвчлэн
ихэнх, ихэнхи	ихэнх
иш / эш	иш (хүрзний ~) эш (эш онол)
лавлагаа / лавалгаа	лавлагаа
маани / маань	маани (~ унших) маань (тэр ~)
магадалгаа / магадлагаа	магадалгаа
махбод / махбодь	махбод
мөрөгцөг / мөргөцөг	мөргөцөг
мөхөсдөх / мөхөстөх	мөхөстөх (энэ бичлэг зөв)
мурий / муруй	мурий (үйл үг) муруй (тэмдэг нэр)
мэдрэхүй / мэдэрхүй	мэдрэхүй
мэргэ / мэрэг	мэргэ
мэргэжил / мэрэгжил	мэргэжил
наадах / наадахь	наадах
наалданги / наалданга	наалданги

нааших / нааши	нааших
навтганах / навтаганах	навтганах
наймаалж / наймалж	наймалж
нармагар / нармигар	нармигар (хүний хамрын төрх)
нижигнэх / нижгэнэх	нижигнэх
нил / нэл	нэл (бүхэлдээ)
нил цэцэг	
нисэгч / нисгэгч	нисгэгч пилот нисэгч (сансрын нисэгч)
номхтгох / номхотгох	номхотгох
нотолгоо / нотлогоо	нотолгоо
нөгөөтээгүүр / нөгөөтэйгүүр	нөгөөтээгүүр
нөгчих / нөхцөх	нөгчих (нас ~), нөхцөх (нийлэх)
нударга / нудрага	нударга
нулимс / нулимас	нулимс
нурамгар / нурмагар	нурмагар
нүжигнэх / нүжгэнэх	нүжигнэх
нэг бүр / нэгбүр	нэг бүр
нэг мөр / нэгмөр	нэг мөр
нэгмөсөн / нэг мөсөн	нэгмөсөн
нэгэнтээ / нэгтээ	нэгэнтээ
нэгэнтээгүүр / нэгтээгүүр	нэгэнтээ (нэгэнтээгүүр гэсэн хэлбэрийг бичигт хэрэглэхгүй)
нэжгээд / нижгээд	нэжгээд
нэлээд / нилээд	нэлээд
нэлмэгэр / нэлэмгэр	нэлмэгэр
нэлэнхий / нэлэнхүй	нэлэнхий

2.1.3. О-Т

Хувилбарууд	Журамласан жагсаалт
овилгогүй / овлигогүй	овилгогүй
овьёос / овъёос	овьёос
оготно / огтоно	оготно
ойрх / ойрхи	ойрх
олонлог / олонлиг	олонлог
олонтоо / олонтаа	олонтоо
олонх / олонхи	олонх
оношилгоо / оношлогоо	оношилгоо
оодгонох / оодогнох	оодгонох
орвогонох / оровгонох	орвогонох
отог / отго	отог аймаг отго жинс
оюунлаг / оюунлиг	оюунлаг
өв тэгш / үв тэгш / өвтэгш	өвтэгш
өгүүлэх / үгүүлэх	өгүүлэх
өгүүлбэр / үгүүлбэр	өгүүлбэр
өгүүллэг / үгүүллэг	өгүүллэг
өгүүлэгдэхүүн / үгүүлэгдэхүүн	өгүүлэгдэхүүн
өгүүлэхүүн / үгүүлэхүүн	өгүүлэхүүн
өгүүлэл / үгүүлэл	өгүүлэл
өлөг / өлгө [эд ~]	өлөг (эд ~)
өмнөд / өмнөт	өмнөд
өмхий / үмхий	өмхий
өнтэй / өнөтэй	өнтэй
өрвөлөг / өрөвлөг	өрвөлөг
өргөдөл / өрөгдөл	өргөдөл
өш / өс	өш өс
өшиглөх / өшгөлөх	өшиглөх

пижигнэх / пижгэнэх	пижгэнэх
саарь / сайр	саарь (гарын ~) сайр (голын ~)
сагалдарга / сагалдрага	сагалдарга
саглагар / сагалгар	саглагар
сайхь / саахь [~ хүн]	сайх (нөгөө) саях (саяын) (саахь-ийг хэрэглэхгүй)
саланги / саланга	саланги
санаачилга / санаачлага	санаачилга
сарваганах / саравганах	сарваганах
саримс / сармис / саримсаг	саримс саримсаг (аль ч хэлбэрийг хэрэглэж болно)
сарьдаг / саридаг	сарьдаг
сонгууль / сонгуул	сонгууль
сонсогдох / сонсдох / сонстох	сонсогдох сонстох (аль ч хэлбэрийг хэрэглэж болно)
сорви / сорив	сорви
сормуус / сормос	сормуус
суварга / суврага	суварга
судлагдахуун / судалгдахуун	судлагдахуун
сурвалжилга / сурвалжнага	сурвалжилга
сургаал / сургааль	сургаал
сурталчилгаа / сурталчлагаа	сурталчилгаа
суртахуун / суртхуун	суртахуун
сүсэг / сүжиг	сүсэг (~ бишрэл) сүжиг (~ээр эдгэх)
цэрвүү / ээрвүү	цэрвүү
сэрвэгэр / ээрвэгэр	сэрвэгэр
сэргэмж / ээрэмж	сэрэмж (сэргэмж-ийг бичигт хэрэглэхгүй)
сэргигнэх / ээржгэнэх	сэргигнэх
тавтир / тавьтир	тавтир

тасхийм / тэсгим / тэсгэм	тасхийм / тэсхийм (найруулгын ялгаатай хэрэглэж болно)
ташрам / дашрам	ташрам
титэм / титим	титэм
товъёг / товъёог	товъёг
тогтонги / тогтонг	тогтонги
тожигнох / тожгонох	тожгонох
томчууд / томчуул	томчууд томчуул (аль ч хэлбэрийг хэрэглэж болно)
томьёо / томъёо	томъёо
тохьгүй / тохигүй	тохьгүй
тошлог / тошлой	тошлог тошлой (аль ч хэлбэрийг хэрэглэж болно)
төвд / түвд	төвөд
төвөг / түвэг	түвэг
төвөнх / төвөн	төвөнх
төвшин / түвшин	төвшин (төв ~) түвшин (далайн ~)
төлгө / төлөг	төлгө (мэргэ төлгө) төлөг (2 настай хонь)
төрөлхтөн / төрлөхтөн	төрөлхтөн
тугтам / тутам	тугтам (бичгийн хэлний сонгодог найруулгад хэрэглэж болно)
тунадас / тундас	тунадас
турхирах / тухирах	турхирах тухирах
тутам / дутам	тутам
туурвил / туурьвил	туурвил
тэнгис / тэнгэс	тэнгис
тээршээх / тээршаах	тээршээх

2.1.4. У-Я

Хувилбарууд	Журамласан жагсаалт
увдис / увидас / увьдис	увдис
удаах / удаахь	удаах
уйланхай / уйлхай	уйланхай
улхганах / улхагнах	улхганах
ундарга / ундрага	ундарга
урай / ура	урай
урий / уруй	уруй
уруу / руу	уруу (~ газар) руу (хот ~)
урьдах / урдах	урьдах (цаг хугацааны) урдах (орон байрын)
уушги / уушиг	уушги
үрчлээ / үрчлээс	үрчлээ үрчлээс (аль ч хэлбэрийг хэрэглэж болно)
үүлдэр / үүлтэр	үүлдэр
үүрд / үүрт	үүрд
үүсвэр / үүсгэвэр	үүсвэр
хааш яаш / хайш яйш	хааш яаш
хавсрах / хавсарах	хавсрах
хавчганах / хавчигнах	хавчганах
хавьгүй / хавигүй	хавьгүй
хайхрах / хайхарах	хайхрах
халти мөлт / хальт мөлт	халти мөлт
халтирах / хальтирах	халтирах
хангарди / хангарьд	хангарди
харьяа / харъяа	харьяа
хатангир / хатингар	хатангир
хахуул / хахууль	хахуул (~аар загас барих) хахууль (хээл ~ өгөх)

хашхирах / хашгирах	хашхирах
хижээл / хэжээл	хижээл
хир / хэр	хир (~ буртаг) хэр (~ хэмжээ, энэ ~)
хиртхийх / хэртхийх	хиртхийх
хоёрдахь / хоёрдох	хоёр дахь
хойгуурх / хойгуурхи	хойгуурх
хойд / хойт	хойд
хойших / хойши	хойших
холхи / холхь ~ газар	холхи
хомстох / хомсдох	хомсдох
хошуу / хушуу	хошуу (хоншоортой нэг язгуурт үг)
хошууч / хушууч	хошууч
хошхирох / хошгирох	хошхирох
хөвгүүн / хөвүүн	хөвүүн
хөвөх	хөвөх
хөврөл / хүврэл	үр (~ хөврөл)
хөврөх / хүврэх	хөврөх
хөдлөнги / хөдлөнгө	хөдлөнгө
хөлөг / хүлэг	хөлөг (~ онгоц) хүлэг (~ морь)
хөмүүл / хүмүүл	хөмөл
хөөмий / хөөмэй	хөөмий
хөрөв / хөрвө	хөрөв (~ хурга)
хөхүүлэх / хөхиүлэх	хөхүүлэх (хургаа ~) хөхиүлэх (~н дэмжих)
хөшинги / хөшингө	хөшингө
хуваарилах / хувиарлах	хуваарилах
хуваарь / хувиар	хуваарь
хударга / хударга	хударга
хулчганах / хулчиганах	хулчганах
хунтайж / хуантайз / хуантайж	хунтайж (хуантайж-г хэрэглэхгүй)

хурай / урай	хурай
хошуу / хушуу	хушуу (засаг захиргааны нэгж)
хүрлэгэр / хүрэлгэр	хүрлэгэр
хүртэлх / хүртлэх	хүртэлх
хэвлий / хэвэл	хэвлий
хэддэх / хэддэхь	хэд дэх
хэлсэнчлэн / хэлсэнчилэн	хэлсэнчлэн
хэлэлцээ / хэлэлцээр	хэлэлцээ (яриа ~) хэлэлцээр (гэрээ ~)
хэмлэх / химлэх	хэмлэх
хэншүү хиншүү	хэншүү
хэрэв / хэрвээ	хэрвээ
хэрэглэгдэхүүн / хэрэглэгдхүүн	хэрэглэгдэхүүн
хэхрэх / хэхэрэх	хэхрэх
хэчнээн / хичнээн	хэчнээн
хяхтнах / хяхатнах	хяхтнах
цаадах / цаадахь	цаадах
цааших / цааших	цааших
цагаадах / цагаатах	цагаадах
цагариг / цагираг	цагариг
цадиг / цэдиг	цадиг
цовхрох / цовхорох	цовхрох
цоморлог / цоморлиг / цомирлог	цоморлог
цомтгох / цомхтгох	цомхотгох
цомтгол / цомхтгол	цомхотгол
цөөнх / цөөнхи	цөөнх
цусдах / цустах	цусдах (гараа ~) цустах (шилж. утга)
цуурай / цууриа	цуурай
цүдгэнэх / цүдэгнэх	цүдгэнэх
цүдгэр / цүзгэр	цүдгэр
цэн / цэнэ	цэн

цэцгий / цөцгий	цэцгий (нүдний ~) цөцгий (~н тос)
цэцэн / сэцэн	цэцэн (мэргэн) сэцэн (цол)
цээж / чээж	чээж
чавхдас / чавхадас	чавхдас
чанад / чинад	чанад
чандмань / зэндмэнэ	чандмань (эрдэнэ) зэндмэнэ (тоглоом)
чармаа / чармай [~ нүцгэн]	чармаа (~ нүцгэн)
чахрах / чихрах	чахрах
чацуу / сацуу	чацуу (нас ~) сацуу (ирэхийн ~)
чүдэнз / шүдэнз	чүдэнз
шавж / шавьж	шавж
шамарга / шамрага	шамарга
шарагчин / шаргагчин	шарагчин (жилийн) шаргагчин (зүс)
шаргуу / шургуу	шаргуу
шармигар / шаримгар	шармигар
шастир / шаштир	шастир
шатахуун / шатхуун	шатахуун
шашин / шажин	шашин (~ы сургаал) шажин (бурхны ~)
шидмэс / шидэмс	шидэмс
шударга / шудрага	шударга
шуламс / шуламс	шуламс
шуухитнах / шуухьтнах	шуухитнах
шээзгий / шээжгий	шээзгий
эдлэхүүн / эдлэгдэхүүн	эдлэхүүн эдлэгдэхүүн
эжий / ижий	эжий
эзлэхүүн / эзэлхүүн	эзлэхүүн

элэн халин / элин халин	элэн халин
эмхтгэл / эмхэтгэл	эмхэтгэл
эрвэгэр / эрэвгэр	эрвэгэр
эрвээхий / эрвээхэй	эрвээхий
эргэнэг / эрэгнэг	эргэнэг (монгол гэрийн эд зүйлийн тавиур)
эргэх / эгэх	эргэх эгэх (найруулгын ялгамжаатай хэрэглэнэ)
эргэцүүлэх / эрэгцүүлэх	эргэцүүлэх
эрих / эрхи	эрих
эrmэлзэл / эrmэлэлэл	эrmэлзэл
эрхт / эрхэт	эрхт
эшлэл / ишлэл	эшлэл
ээдэм / ээдмэг	ээдэм
явуур / явуурь, ~гүй	явуур
яйжгар / яайжгар	яйжгар
яльгүй / ялигүй	яльгүй
ярвагар / яравгар	ярвагар

2.2. Журамласан гадаад үгс

2.2.1. А-Л

Тогтоосон бичлэг	Дуудлага
АВТОБУС [rep.auto+omni]	автобуус
АВТОМАТ [Гер. automates]	автмаат
АГЕНТЛАГ [Лат. rgens (agentis)]	аагентлаг
АГРОНОМ [Гер. agros + nomos]	агроноом
АЗОТ [Гер. a... +zoos]	азоот
АКАДЕМИ [Гер. akademia]	акадеэми
АККУМЛЯТОР [Лат. accumulator]	аккумулятор
АКТИВ [Лат. activus]	актиив

АЛЬБОМ [Фр. album]	альбоом
АНКЕТ [Фр. enquête]	анкеэт
АНТЕН [Лат. antenna]	антеэн
АРБИТР [Фр. arbitre < лат. arbiter]	арбиитр
АУДИТ [Лат. audit]	аудиит
БААР [Англ. bar.]	баар
БАРРЕЛ [Исп. barril]	барреэл
БЕЙСБОЛ [Англ. baseball]	бэйсбоол
БИБЛИ [Гер. biblia-biblion]	бийбли
БИЗНЕС [Англ. business]	бийзнес
БИНГО [Англ. bingo]	биинго
БИРЖ [Герм. Вцгее].	биирж
БИФШТЕКС [Англ. beefsteaks]	бифштеэкс
БЛИЦ [Герм. Blitz]	блиц
БОЙЛЕР [Англ. boiler]	бойлер
БООЛТ [Англ. bolt]	боолт
БОНД [Англ. bond]	бонд
БОРШ [Орос борщ]	боорш
БОСС [Англ. boss]	боосс
БОУЛИНГ [Англ. bowling < to bowl]	боулинг
БРЕЗЕНТ [Голл. presenning]	бирзээнт
БРЕЙК [Англ. break]	брейк
БРИГАД [Фр. brigade]	бригаад
БРОКЕР [Англ. broker]	броокер
БУФЕТ [Фр. buffet]	буфеэд
ВАГОН [Англ. wagon]	вагоон
ВАКУУМ [Лат. vacuum]	ваакуум
ВАКЦИН [Лат. vaccinus]	вакциин
ВАЛЕНТ [Лат. valentia]	валеэнт
ВАЛЬС [Фр. valse < герм. Walzer]	ваальс
ВАЛЮТ [Ит. valuta]	валюут
ВАРИАНТ [Лат. varians, variantis]	вариант

ВАРЬЕТЕ [Фр. <i>variete</i>]	варьезте
ВАУЧЕР [Англ. <i>voucher</i>]	ваучер
ВЕКТОР [Лат. <i>vector</i>]	везктор
ВИДЕО [Лат. <i>video</i>]	видео
ВИЗ [Лат. <i>visa</i>]	вииз
ВИСКИ [Англ. <i>whisky</i>]	вииски
ВЭБСАЙТ [Англ. <i>web</i> + лат. <i>situs</i>]	вэбсайт
ГАЗ [Фр. <i>gaz</i>]	гааз
ГАЛА [Фр. <i>gala</i>]	гаала
ХАМБУРГЕР [Англ. <i>hamburger</i>]	хаамбүүргэр
ГАММА [Гер. <i>gamma</i>]	гаамм
ХАНДБОЛ [Англ. <i>hand-ball</i> < <i>hand</i>]	гандбоол
ГАРААШ [Фр. <i>garage</i>]	гарааж
ГЕНЕТИК [Гер. <i>genetics</i>]	генеэтик
ГРАММ [Фр. <i>gramme</i> < реп. <i>gramma</i>]	граамм
ГРАН-ПРИ [Фр. <i>Grant Prix</i>]	Граан-При
ДААРТС [Англ. <i>darts</i>]	даартас
ДЕПАРТМЕНТ [Фр. <i>departement</i>]	департамент
ДИАГРАММ [Гер. <i>diagramma</i>]	диаграамм
ДИЖИТАЛ [Англ. <i>digital</i>]	дижитаал
ДИЗАЙН [Англ. <i>design</i>]	дизайн
ДИЛЕР [Англ. <i>dealer</i>]	диилер
ДИНОЗАВР [Гер. <i>deinos</i> + <i>sauros</i>]	динозаавр
ДИСКО [Англ. <i>disko</i>]	дииско
ДОЛЛАР [Англ. <i>dollar</i>]	дооллар
ДАНХРААТ ДОМКРАТ [Голл. <i>dommekracht</i>]	домкраат
ЕВРО [Гер. <i>euro</i>]	Евроо
ЕВРОП [Гер. <i>europa</i>]	Еврооп
ЛІСА ЖАЙКА [Англ. <i>Japan International Cooperation Agency</i> гэдгийн товчлол]	ЖАЙКА
ЖАНР [Фр. <i>genre</i>]	жанр

ЖЕНДЕР [Англ. gender]	жеэндер
ЖИЙНС ЖЕНС [Англ. jeans]	жеэнс
ЖИЙП [Англ. jeep]	жиип
ИМИЖ [Фр. image]	иимиж
Э-МЭЙЛ [Англ. E-mail < electronic mail]	имейл
ИННОВАЦИ [Лат. innovation]	инновааци
ИНТЕРПОЛ [Фр. Interpol-Organisation internationale de police criminelle хэмээх нэрийг товчлон хэрэглэсэн нь]	интерпоол
ИНЧ [Англ. inch]	иинч
ИПОТЕК [Гер. hypotheke]	ипотеек
КАДАСТР [Гер. katastichon]	кадаастр
КАКАО [Исп. cacao]	какао
КАМЕР [Лат. camera]	каамер
КАНЦЛЕР [Герм. Kanzler]	Каанцлер
КАРАОКЕ [Англ. караоке<яп.]	караоке
КАРГО [Исп. cargo]	каарго
КАФЕ [Фр. cafe]	кафеэ
КВОТ [Лат. quota]	квоот
КИРИЛ [Болг. Кирилл]	кириил
КОКА-КОЛА [Англ. coca cola]	коока-коола
КОКТЕЙЛ [Англ. cocktail]	коктейл
CD. КОМПАКТ-ДИСК [Англ. compact disc]	компаакт-дииск
КОМПАНИ [Фр. compagnie]	компаани
КОМПЬЮТЕР [Англ. computer]	компьютер
КОНВЕНЦ [Лат. conventio]	конвеэнц
КОНСОРЦИУМ [Лат. consortium]	консоорциум
КОНСТРАКШИН [Лат. constructio]	констраакшин
КОНТРАКТ [Лат. contractus]	контраакт
КОНЦЕРН [Англ. concern]	концеэрн
КОНЦЕСС [Лат. concessio]	концеэсс

КОРПОРАЦ [Лат. <i>corporatio</i>]	корпораац
КОРПУС [Лат. <i>corpus</i>]	коорпус
КОФЕ [Голл. <i>coffie</i> < араб. <i>qahwa</i>]	коофе
КРАНТ [Голл. <i>kraan</i>]	краант
ЛАЗЕР [Англ. <i>laser</i>]	лаазер
ЛИГ [Фр. <i>ligue</i> < Лат. <i>ligo</i>]	лииг
ЛИЗИНГ [Англ. <i>lease</i>]	лиизинг
ЛИЦЕНЗ [Лат. <i>licentia</i>]	лицеэнз
ЛОББИ [Англ. <i>lobby</i>]	лообби
ЛОГО [Англ. <i>logo</i>]	лоого
ЛОМБАРД [Ит. <i>Lombardo</i> < лат. <i>longobardus</i>]	ломбаард

2.2.2. М-Я

Тогтоосон бичлэг	Дуудлага
МАГИСТР [Лат. <i>magister</i>]	магиистр
МАКРО [Гер. <i>makros</i>]	маакро
МАНСАРД [Фр. францын уран барилгач <i>Mansarde</i> -ийн нэрээр]	мансаард
МАРКЕТИНГ [Англ. <i>market</i>]	мааркетинг
МАСТЕР [Гер. <i>mastoras</i>]	маастер
МАФИ [Ит. <i>maf(f)ia</i>]	маафи
МЕНЕЖЕР [Англ. <i>manager</i>]	меэнежер
МЕНЕЖМЕНТ [Англ. <i>management</i>]	менежмеэнт
МЕССЕЖ [Англ. <i>message</i>]	меэссэж
МЕССЕНЖЕР [Англ. <i>messenger</i>]	меэссенжер
МИСС [Англ. <i>miss</i>]	миисс
МОБИКОМ [Англ. <i>mobile + communication/mobicom/1</i>]	мобикоом
МООД [Фр. <i>mode</i>]	моод

МОДЕМ [Англ. modem]	модеэм
МОНИТОРИНГ [Лат. monitor]	монитооринг
НАНО [Франц. nanie]	наано
НОТАРИАТ [Лат. notarius]	нотариат
ОКТАВ [Гер. octava]	октаав
ОЛИГАРХ [Гер. oligarchia]	олигаарх
ОНЛАЙН [Англ. one + line]	онлайн
ПАНТОМИМ [Гер. panto-mimos]	пантомиим
ПАРАОЛИМП [Гер. para+olympos]	паараолимп
ПАРЛАМЕНТ [Герм. Parla-ment, англ. parliament, Ад. parlement < parler]	парлаамент
ПАТЕНТ [Лат. patens (patentis)]	патеэнт
ПАУЗ [Гер. pausis]	пауз
БАЦААН [Орос. пацан]	бацаан
ПЕПСИ [Англ. Pepsi]	пээпси
БИРВААЗ [Орос. пере + воз]	бирвааз
ПИЦЦА [Ит. pizza < pizzicare]	пицца
ПЛЮРАЛИЗМ [Лат. plu-ralis]	плюралиизм
ПОКЕР [Англ. poker]	поокер
ПОЛИГОН [Гер. polygonos]	полигоон
ПОЛО [Англ. polo<төвэд pho long]	пооло
ПРАГМАТИК [Гер. pragma]	прагмаатик
ПРЕЗЕНТАЦ [Лат. praesentatio]	презентаац
ПРИНТЕР [Англ. printer]	приинтер
ПРОГРАММ [Гер. programma]	програамм
ПРОПАН [Гер. propane]	пропаан
ПРОЦЕССОР [Лат. processio]	процессор
ПУУЛ [Англ. pool]	пуул
РАДИАЦ [Лат. radiatio]	радиац
РАДИО [Лат. radiare]	араажав
РАПЛИ [Англ. rally]	раалли
АРААМ [Польш. gama]	араам, хөрөө араам

РЕГБИ [Англ. rugby]	реэгби
РЕГИСТР [Лат. registrum]	региистр
РЕЙТИНГ [Англ. rating]	рейтин
РЕЭКСПОРТ [Лат. re- +'лат exportare = реэкспорт]	реээкспорт
РОБОТ [Чех. robot]	рообот
РУБЛЬ [Орос рубити, обрубок]	руубль
САЙТ [Англ. site]	сайт
СЭНДВИЧ [Англ. sandwich]	сэндвич
САУН [Фин. sauna]	саун
СЕКС [Лат. sexus]	сеэкс
СКАНЕР [Англ. scanner]	скаанер
СКАУТ [Англ. scout]	скаут
СЛАЙД [Англ. slide]	слаайд
СТАТУС [Лат. status]	стаатус
СТИЛЬ [Фр. style]	стииль
СТРАТЕГИ [Гер. strategia < stratos + ago]	стратеэги
СТУДИ [Ит. studio]	стууди
СУПЕР [Лат. super]	суупер
СУПЕРМАРКЕТ [Лат. super + англ. market]	суупермааркет
ТАРИФ [Фр. tarif]	тарииф
ТЕЛЛЕР [Англ. teller]	теэллер
ТЕНДЕР [Англ. tend + er]	теэндер
ТЕРРОРИЗМ [Лат. terror]	терроризм
ТРАНСКРИПЦИИ [Лат. trans-criptio]	транскриипци
ТРАНСЛИТЕРАЦИИ [Лат. translittera]	транслитерааци
ТРОЛЛЕЙБУС [Англ. trolley-bus]	троллейбус
УНЦ [Лат. uncia]	уунци
ФАЙЛ [Англ. file]	файл
ФАКС [Англ. fax < фр. facsimile < лат. fac simile]	фаакс

ФЕРМЕР [Англ. farmer]	фээрмер
ФУНКЦ [Лат. functio]	фуункц
ФУРГОН [Фр. fourgon]	фургоон
ХАЙПЕРМАРКЕТ [Лат. hyper + англ. market]	хайпермаркет
ХОЛЕСТЕРИН [Гер. chole + stereos]	холестериин
ЦЕЛЛОЙД [Лат. cellula + реп. eidos]	целлойд
ШОРТ [Англ. shorts-short]	шоорт
ШОУ [Англ. show]	шоу
ЭКВИВАЛЕНТ [Лат. aequiva-lens, aequivalentis]	эквивалеэнт
ЭКОЛОГИ [Гер. oikos + logos]	эколооги
ЭКСТРЕМИЗМ [Лат. extremus]	экстремизм
ЭНЕРГИ [Гер. energeia]	энеэрги
ЭСЭЭ [Фр. essay]	эсээ
ЭХОГРАММ [Герм. Echo < лат. eco < реп. echo]	эхограамм
UNESCO- ЮНЕСКО [Англ. United Nations Educational, Scientific and Cultural Organization]	ЮНЕСКО
ABS- ЭЙ-БИ-ЭС [Англ. American Broadcasting System нэрийн товчлол/ABS/]	эйбиэс

2.3. Орчуулан хэрэглэх үгс

Орчуулах гадаад үг болон тэдгээрийн дуудлага	Монгол орчуулга
БЕСТСЕЛЛЕР [Англ. bestseller] бэстсеэллэр	Онцгой гүйлгээт ном
БИЗНЕСМЕН [Англ. businessman] бийзнесмээн	Ажил хэрэгч хүн
БОДИБИЛДИНГ [Англ. body-building] бодибиилдин	Бялдаржуулал
БОНУС [Лат. bonus].	Боонус Урамшуулал(-цалин)
БРЭНД [Англ. brand] брээнд	Сор(-бүтээгдэхүүн)
ВАРЕНИ [Орос вар + ен + ъе1 варезни	Чанамал
ВЕНА [Лат. vena] везн	Хураагуур(-судас)
ДЕТЕКТИВ [Англ. detective < лат. detectio] детектиив	Адал явдал
КАМПАНИ [Фр. campagne] кампаани	Аян (сонгуулийн-, атрын-)
КАМПУС [Англ. campus] каампус	Хотхон (сургуулийн-)
КАССЕТ [Фр. cassette] кассеэт	Хуурцаг
КИБЕРНЕТИК [Гер. kyber-netike] кибернеэтик	Залуурзүй
КОМПЛЕКС [Лат. complexus] коомплекс	Цогц (-үйлдвэр)
КОМПЛЕКТ [Лат. completus] коомплект	Иж (-хоол)
КОНТЕЙНЕР [Англ. container] контейнер	Чингэлэг
ЛЕДЕРИН [Герм. leder] ледерин	Хиймэл арьс
МАНЕКЕН [Фр. mannequin] манекен	Загвар өмсгүүр
МИКР [Гер. mikros] миикр	Бичил (-автобус)
МОНИТОР [Фр. moniteur] мониитор	Дэлгэц
НОТЕБУК [Англ. notebook] ноутбук	Зөврийн компьютер
ПАРКЕТ [Фр. parquet]	Шахмал (-шал)
ПОТЕНЦИАЛ [Лат. potential] потенциал	Чадамж

ПРОДАКШИН [Англ. production] продакшин	Үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, найрууламж
ПРОДЮСЕР [Англ. producer < лат. producerel продюсер	Кино бүтээгч
РЕСЕЙПШИН [Лат. receptio] ресейпшин	Хүлээн авах (зочид буудлын-)
СЕРТИФИКАТ [Лат. certum + facere] сертификаат	Батламж
СКОТЧ [Англ. scotch] скооч	Наалтууз
СТРЕСС [Англ. stress] стресс	Бухимдал, дарамт (сэтгэлийн-)
СЮРПРИЗ [Фр. surprisel сюрприиз	Гэнэтийн бэлэг
ХИТ [Англ. hit] хийт	Шалгармал
ШАМПУН [Англ. shampoo] шаампунь	Шингэн саван